



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Өмнөговь аймгийн төрийн байгууллагуудад өгөх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ

Судалгааны тайлан

2023 он

Агуулга

СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ	4
1. УДИРТГАЛ	5
1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО	6
1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛТ	6
2. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	6
2.1 ТҮҮВРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	7
2.2 ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ	7
2.3 ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГ ТООЦОХ АРГАЧЛАЛ	8
2.4 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ	8
3. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	8
3.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
3.2 ҮР ДҮН – САЛБАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	11
3.2.1 Эрүүл мэнд	12
3.2.2 Боловсрол соёл, спорт	12
3.2.3 Нийтийн тээвэр	14
3.2.4 Дэд бүтэц	14
3.2.5 Аюулгүй байдал шударга ёс	15
3.2.6 Хүнс, хөдөө аж ахуй	16
3.2.7 Эрүүл орчин	17
3.2.8 Ажил эрхлэлт, нийгмийн даатгал	17
3.2.9 Татварын үйл ажиллагаа	18
3.2.10 Уул уурхайн үйл ажиллагаа	19
3.2.11 Батлан хамгаалах	19
3.2.12 Засаглал	20
3.3 ҮР ДҮН –ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖ	21
3.3.1 Төрийн үйлчилгээний чанар	21
3.3.2 Төрийн үйлчилгээний хүртээмж	22
3.3.3 Төрийн үйлчилгээний албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй	22
3.3.4 Төрийн байгууллагын орчин	23
3.3.5 Хамгийн сүүлд авсан үйлчилгээ, үйлчилгээний төрөл	23
3.3.6 Хүссэн үйлчилгээгээ авч чадсан эсэх	24

3.3.7 Түргэн шуурхай байдал, хүнд суртал.....	25
3.3.8 Төрийн байгууллагын үйлчилгээний мэдээллийг авах эх сурвалж.....	26
3.3.9 Төрийн албан хаагчийн мэдээллийн нээлттэй байдал	26
3.4 ҮР ДҮН – САЛБАР, ЧИГ ҮҮРГИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ	27
3.5 ҮР ДҮН – ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ.....	29
3.6.ҮР ДҮН –ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ.....	33
4. ДҮГНЭЛТ.....	34
5. ЗӨВЛӨМЖ.....	36
Хавсралт.....	38

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны зорилго нь Өмнөговь аймгийн сумдын Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход оршино. Судалгааг Өмнөговь аймгийн 13 сумд зохион байгуулсан ба нийт 1723 иргэнийг боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал, орлогын түвшин зэргийг харгалзан судалгаанд түүвэрлэн хамруулсан.

Судалгааны зарим үр дүнгээс энэ хэсэгт хураангуйлан дурдвал:

Ерөнхий үнэлгээ: Аймгийн ЗДТГ болон сумын үйл ажиллагаанд өгөх иргэдийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ 3.76 буюу иргэдийн сэтгэл ханамж сайн боловч зарим салбар, чиг үүргийн үнэлгээг сайжруулах шаардлагатай бөгөөд Даланзадгад сумын 5 болон 8 – р баг, Баян-Овоо, Номгон, Гурвантэс, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сумын иргэд “маш сайн” болон “сайн” үнэлгээтэй байна. Уул уурхай үйл ажиллагаа явуулдаг Ханбогд болон Цогтцэций сумынхан аймгийн ерөнхий үнэлгээнээс харьцангуй бага буюу иргэд сэтгэл ханамжтай бүс байна.

Төрийн байгууллагад ажилладаг иргэд салбар болон төрийн үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдалд илүү сэтгэл ханамжтай байгаа бол олон улсын байгууллагад ажилладаг иргэд хамгийн бага, хувийн хэвшил болон хувиараа бизнес эрхэлдэг иргэдийн сэтгэл ханамж дунджаас доогуур байна.

Хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэйчүүдийн сэтгэл ханамж эмэгтэйчүүдээс 0.13 пунктээр илүү байна. Насны бүлгээр 24 нас хүртэлх залуучууд болон 65-аас дээш насныхан сэтгэл ханамж өндөртэй байгаа бол 34-44 насны иргэдийн сэтгэл ханамж хамгийн бага байна. Боловсролгүй болон бага боловсролтой иргэд боловсрол өндөртэй иргэдээс илүү сэтгэл ханамжтай байна.

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны салбарын чиг, үүргийн дундаж үнэлгээ 3.37 байна. Судалгаагаар эрүүл мэнд болон боловсрол, соёл, спортын салбарын үнэлгээ иргэдээс “сайн” гэсэн үнэлгээ авсан байна. Эрүүл мэндийн салбарын хувьд эмнэлгийн ачаалал, эмнэлгийн үйлчилгээний чанар, эмнэлгийн дотоод орчны тав тухтай байдалд иргэд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж өндөр үнэлгээ өгчээ. Боловсролын салбарын үйл ажиллагаанд ЕБС-ын сургалтын орчин нөхцөл, сургалтын материал, сургалтын чанар, багш нарын үр чадвар болон цэцэрлэгийн багш нарын үр чадвар гэсэн 4 үзүүлэлт сайн гэсэн үнэлгээг эцэх эх, асран хамгаалагчдаас авчээ.

Иргэдийн үнэлгээгээр хамгийн муу салбараар уул уурхайн үйл ажиллагаа 2.84 -аар үнэлэгджээ. Газрын доройтол, цөлжилтөөс хамгаалах нөхөн сэргээх чиглэлийн үйл ажиллагаа хангалтгүй буюу 2.69 байна. Иймээс Орон нутгийн онцлогоос шалтгаалсан уул уурхайн үйл ажиллагаа нь

газрын хөрс, газрын нөхөн төлжилтийг үгүй болгож байгаа тул сэргээх, нөхөн төлжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. Ажлын байрны сонгон шалгаруулалтын шударга байдалд 2.75 гэсэн үнэлгээ өгчээ.

Салбар чиг, үүргийн дундаж үнэлгээг сумдаар харьцуулахад Даланзадгадын 5 болон 8 – р баг, Цогт-Овоо сумын үзүүлэлт сайн гэсэн үнэлгээтэй байна. Ханбогд сум хамгийн бага үнэлгээтэй байна.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээ нь 4.15 буюу сайн түвшинд байна.

Судалгаанд хамрагдсан иргэд төрийн үйлчилгээний чанарыг **3.18** буюу сайн гэж үнэлсэн байна. Үүнээс харахад иргэд төрийн үйлчилгээний талаар санал гомдлоо, илэрхийлэх боломж бүрдсэн, хариу мэдээлэл өгөх байдал хангалттай түвшинд мөн албан хаагчдын ажлын бүтээмж өндөр, мэдлэг үр чадвартай хэмээн үнэлсэн байна.

Төрийн үйлчилгээний хүртээмжийг **3.26** буюу сайн гэж үнэлсэн байна. Төрийн үйлчилгээний хүртээмж нь үйлчилгээний ачаалал, бүрдүүлэх материалын ойлгомжтой байдал, мэдээллийн хангалттай байдал, асуудлын хүрээнд мэдээлэл, зөвлөгөө авах боломжтой байх зэрэг 4 үзүүлэлтээс бүрдэж байгаа юм. Эдгээр бүх үзүүлэлтүүдэд иргэд сэтгэл ханамжтай байгаагаас гадна үйлчилгээг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх зэрэг энгийн ойлгомжтой байдал нь их таалагджээ. Сумын иргэдийн хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөө авах боломжтой байдал нь **3.29** буюу өндөр үзүүлэлттэй байна.

Төрийн ажилтнуудын иргэдэд туслах хандлага, эерэг таатай харилцаа, хариуцлагатай байдал, асуудлыг шийдвэрлэх байдал, ижил тэгш харилцаа хандлагыг гаргах зэрэг үзүүлэлтэд сайн гэсэн үнэлгээг өгсөн байна

Иргэд төрийн байгууллагын орчныг 4 үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн бөгөөд дундаж үнэлгээ **4.2** буюу сайн гэж үнэлэгдсэн байна. Өөрийн орон нутгийн төрийн байгууллагын гадна доторх тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтой харагдахуйц гэж үзэж байна. Мөн хүлээлгийн танхим, шаардлагатай маягт бал үзэг хангалттай байдаг хэмээн үнэлсэн бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх дээр бусад үзүүлэлтээс бага үнэлгээг өгсөн байна.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээг сум, баг гэсэн **20** талбараар харьцуулахад **7** сум, баг маш сайн, **10** нь сайн, 3 нь дундаж үнэлгээ авсан байна.

Иргэд, гэр бүлийн өрхийн орлого өнгөрсөн жилийн хугацаанд **28.26** хувь буюу судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 4 хүн тутмын нэг нь өрхийн амьжиргаа мэдэгдэхүйц болон бага зэрэг дээшилсэн гэж мэдээлжээ.

1. УДИРТГАЛ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан ”Бодлогын бичиг баримын хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг

журам”- ын 9.6, 9.7, 9.8 –д заасны дагуу төрийн захиргааны байгууллага жил бүр Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэнэ.

Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамжийн 2.1 т Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар нь хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэнэ гэж заасан.

Дээрх удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн ЗДТГ-аас зарласан сонгон шалгаруулалтад “Блү Пойнт” ХХК нь шалгарч, хэрэглэгчийн үнэлгээний судалгааны тайланг дараах үе шаттайгаар боловсруулав.

1. *Судалгааны бэлтгэл ажил*: судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл судлах, асуулгын маягт боловсруулах;
2. *Судалгаа зохион байгуулах*: түүвэрлэлт, мэдээлэл цуглуулалт;
3. *Мэдээлэл дүн шинжилгээ хийх*: мэдээлэл боловсруулалт, үнэлэлт дүгнэлт өгч, урьдчилсан тайланг бэлтгэх;
4. *Тайлан боловсруулж, хүргүүлэх*: эцсийн тайланг бэлтгэж, захиалагчид хүргүүлэх;

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Өмнөговь аймгийн сумдын Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг тодорхойлж үнэлгээ хийнэ:

1. Өмнөговь аймгийн ЗДТГ-ын салбар, чиг үүргийн үнэлгээ хийх;
2. Өмнөговь аймгийн ЗДТГ-ын үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох;
3. Өмнөговь аймгийн бодлого, үйл ажиллагаа иргэдэд хүрсэн байдлыг үнэлэх;
4. Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар иргэдийн саналыг авах, судлах;
5. Судалгааны үр дүнд үндэслэн санал зөвлөмж боловсруулах;


2. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Өмнөговь аймгийн хэрэглэгчийн үнэлгээнд тоон судалгааны аргыг ашиглалаа. Үнэлгээний арга зүйн дагуу иргэдийн төлөөлөөс Сэтгэл ханамжийн судалгааны асуулгыг мэдээлэл цуглуулагч

нар иргэдийн гэрээр зочилж асуулгын хуудасны асуултуудыг нэг бүрчлэн асууж, бөглөх зарчмаар мэдээллийг цуглуулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017.12.15 өдрийн 302 дугаар тушаалд заасан санал асуулгын хуудсыг ашигласан болно.

2.1 ТҮҮВРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг Өмнөговь аймгийн 13 сумын насанд хүрсэн 1723 иргэнээс ганцаарчилсан ярилцлага, асуулга судалгааны аргаар мэдээлэл цуглуулав. Судалгаанд өрхөөс насанд хүрсэн нэг оролцогчийг сонгож судалгаанд хамруулав. Судалгааны асуумжууд нь иргэдийн ерөнхий мэдээллээс гадна салбар чиг үүргийн үнэлгээ, үйлчилгээний чанар хүртээмжийн үнэлгээ гэсэн нийт 3 бүлэг бүхий багц 85 асуумжтай.



Зураг 1. Судалгаанд хамрагдсан сумууд

2.2 ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

Судалгааны мэдээллийг Өмнөговь аймгийн 13 сумын 18 -аас дээш насны иргэдээс ± 3 хувийн алдааны хязгаар дотор 95 хувийн итгэлтэйгээр төлөөлөх чадвар бүхий 1723 иргэнийг асуулга судалгаанд хамрууллаа.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо, сум болон багаар

№	Сумын нэр	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо		Нийт
		Эрэгтэй	Эмэгтэй	
1	Даланзадгад 1-р баг	32	113	145
2	Даланзадгад 2-р баг	27	43	70

3	Даланзадгад 3 - р баг	38	59	97
4	Даланзадгад 4 - р баг	27	50	77
5	Даланзадгад 5 - р баг	21	44	65
6	Даланзадгад 6 - р баг	41	97	138
7	Даланзадгад 7 - р баг	19	50	69
8	Даланзадгад 8 - р баг	33	40	73
9	Баян-Овоо	26	22	48
10	Булган	23	35	58
11	Гурвантэс	56	76	132
12	Мандал-Овоо	13	30	43
13	Манлай	26	42	68
14	Сэврэй	25	30	55
15	Ханбогд	63	141	204
16	Ханхонгор	20	26	46
17	Хүрмэн	13	29	42
18	Цогт-Овоо	19	31	50
19	Цогтцэций	61	114	175
20	Номгон	25	43	68
	Нийт	608 (35.3%)	1115 (64.7%)	1723(100%)

2.3 ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Санал асуулгын асуулт бүрийг 1-5 оноогоор үнэлэх бөгөөд 1- маш муу, 2- муу, 3- дунд, 4-сайн, 5- маш сайн, 0-мэдэхгүй, хариулах боломгүй гэсэн сонголтууд байна.

Асуултын үнэлгээг тус бүрийн дундаж утгаар тодорхойлсон ба энэ нь 0-5 хүртэлх оноо байна. Хэрэглэгчийн үнэлгээнд эзлэх жингийн хувьд салбар чиг үүргийн үнэлгээ 70.0 хувь, үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ 30.0 хувийг тус тус эзэлнэ. Салбарын дундаж үнэлгээ, үйлчилгээний дундаж үнэлгээ болон ерөнхий үнэлгээг Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамжид заасан үнэлгээний дүнг тооцох аргачлалын дагуу судалгааны үр дүнг боловсрууллаа.

2.4 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Судалгааны бүх мэдээллийг SPSS (Statistical Package for Social Sciences) статистикийн программ Window Version 24.0 (SPSS, Inc, Chicago, IL, USA) ашиглан боловсруулсан. Товлосон өгөгдлүүдийг тоо болон хувиар илэрхийлж судалгаандаа тусгав. График, зургийг мөн SPSS программ дээр хийж гүйцэтгэв.

3. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгааны анхдагч мэдээлэл цуглуулах явцад судалгаанд оролцогчдын нас, хүйс болон боловсролын хувьд олон ялгаатай бүлгийг төлөөлж чадахуйц байлгахгаар төлөвлөж ажилласан. Судалгаанд оролцогчдын 35.3 хувь нь эрэгтэй, 64.7 хувь нь эмэгтэй байна. Нийт судалгаанд оролцогчдын 9.9 хувь нь 24 хүртэлх насныхан, 33.3 хувь нь 25-34 насныхан, 26.4 хувь нь 35-44 насныхан, 12.9 хувь нь 45-54 насныхан, 12.5 хувь нь 55-64 насныхан, 4.9 хувь нь 65-аас дээш насныхан хамрагдсан байна.



Зураг 2. Судалгаанд хамрагдсан иргэдийн нас, хүйсээр (n=1723)

Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой судалгаанд оролцогчид 38.1 хувь, бүрэн дунд боловсролтой 27.8 хувь, суурь боловсролтой 10.0 хувь, бага боловсролтой 5.3 хувь, боловсролгүй иргэд 0.9 хувийг эзэлсэн байна.


Ажил эрхлэлтийн хувьд төрийн байгууллагад ажиллагчид 26.5 хувь, хувийн байгууллагад 18.5 хувь, хувиараа хөдөлмөр эрхэлдэг 16.1 хувь, тэтгэврийн иргэд 13.5 хувь, эрхэлсэн ажилгүй 11.9 хувь, төрийн бус байгууллагад 4.8 хувь, олон улсын байгууллагад ажилладаг 0.5 хувь, бусад 8.3 хувийн төлөөлөлтэй хамрагдсан нь судалгаанд хамрагдсан иргэдийн ажил эрхлэлтийн бүтцийг төлөөлсөн байна.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагсдын ерөнхий мэдээлэл (n=1723)

№	Үзүүлэлт	Давтамж	Эзлэх хувь
1	Хүйс		
	Эрэгтэй	608	35.3%
	Эмэгтэй	1115	64.7%

2	Насны бүлэг	24 хүртэл	170	9.9%
		25-34	574	33.3%
		35-44	455	26.4%
		45-54	223	12.9%
		55-64	216	12.5%
		65-аас дээш	85	4.9%
3	Боловсрол	Боловсролгүй	16	.9%
		Бага	92	5.3%
		Суурь	172	10.0%
		Бүрэн дунд	479	27.8%
		Техник болон мэргэжлийн дунд /МСҮТ/	149	8.6%
		Тусгай мэргэжлийн дунд	159	9.2%
		Дээд	656	38.1%
3	Хөдөлмөр эрхлэлт	Ажилгүй	205	11.9%
		Төрийн байгууллага	457	26.5%
		Төрийн бус байгууллага	82	4.8%
		Олон улсын байгууллага	8	.5%
		Хувийн хэвшил, компани	318	18.5%
		Хувиараа бизнес эрхэлдэг	278	16.1%
		Өндөр насны тэтгэвэрт	232	13.5%
		Бусад	143	8.3%
4	Өрхийн сарын орлого	250,000 ₮ хүртэл	140	8.1%
		250,001-500,000₮	154	8.9%
		500,001-750,000₮	247	14.3%
		750,001-1,000,000₮	219	12.7%
		1,000,001-1,500,000₮	401	23.3%
		1,500,001-2,000,000₮	267	15.5%
		2,000,001-аас дээш	295	17.1%
Дүн			1723	100%

Судалгаанд хамрагдсан оролцогчдын хувьд 250000 хүртэлх төгрөгийн орлоготой өрх 8.1 хувь, 250,001-500,000 орлоготой 8.9 хувь, 500,001-750,000 орлоготой 14.3 хувь, 750,001-1,000,000 орлоготой 12.7 хувь, 1,000,001-1,500,000 орлоготой 23.3 хувь, 1,500,001-2,000,000 орлоготой 15.5%, 2 саяас дээш төгрөгийн орлоготой өрх 17.1 хувийг эзэлж байна.



Зураг 3. Иргэдийн амьжиргааны түвшин (n=1723)

Судалгаанд оролцогчдын 55.31 хувь нь өрхийн амьжиргаагаа өнгөрсөн жилтэй харьцуулахад “хэвэндээ” байна гэж үзэж байгаа бол 21.3 хувь нь бага зэрэг, 6.96 хувь нь мэдэгдэхүйц дээшилсэн гэж хариулсан байна.

Стратегийн зорилго:

Өмнөговь аймгийн иргэд, гэр бүлийн орлого өсөх боломжийг бүрдүүлж, тэдний боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, иргэдийн итгэл хүлээсэн төрийн албыг төлөвшүүлж, амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.


Судалгааны үр дүнгээс харахад Стратегийн зорилгын гол үзүүлэлт болох иргэд, гэр бүлийн өрхийн орлого өнгөрсөн жилийн хугацаанд 28.26 хувь буюу судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 4 хүн тутмын нэг нь өрхийн амьжиргаа мэдэгдэхүйц болон бага зэрэг дээшилсэн гэж мэдээлжээ.

3.2 ҮР ДҮН – САЛБАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Өмнөговь аймгийн ЗДТГ – ын салбарын сэтгэл ханамжийн үнэлгээ нь нийт 12 салбаруудын үйлчилгээг үнэлсэн. Салбарууд нь эрүүл мэнд; боловсрол, соёл, спорт; нийтийн тээвэр; дэд бүтэц; аюулгүй байдал, шударга ёс; хүнс, хөдөө аж ахуй; эрүүл орчин; ажил эрхлэлт, нийгмийн даатгал; татварын үйл ажиллагаа; уул уурхай үйл ажиллагаа; батлан хамгаалах; засаглал зэргээс бүрдэнэ.

Салбарын үйлчилгээ тус бүр нь дотроо 3-9 хүртэлх тооны хоорондоо харилцан уялдаа бүхий үзүүлэлтүүдийг агуулсан нийт 61 үзүүлэлттэй.

3.2.1 Эрүүл мэнд




Зураг 4. Эрүүл мэндийн салбарын үнэлгээ (n=1232)

Судалгаанд хамрагдсан иргэдийн 71.5 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд аймаг, сумын эмнэлгээр үйлчлүүлсэн бөгөөд эрүүл мэндийн салбарын үйлчилгээнд 3.99 буюу "сайн" гэсэн үнэлгээг өгсөн байна. Иргэд үйлчлүүлсэн эмнэлгийнхээ дотоод орчны тохилог, тав тух, цэвэрхэн байдалд 4.37 буюу сайн үнэлгээ өгсөн нь сэтгэл ханамжтай байгааг илэрхийлж байна. "Эрт илрүүлэг" үзлэг оношилгооны хүртээмжид 3.71 үнэлгээг өгчээ. Даланзадгад сумын 8-р баг болон Гурвантэс сумын иргэд эрүүл мэндийн салбарын үйлчилгээнд илүү сэтгэл ханамжтай байна. Насны бүлгээр авч үзэхэд 65-аас дээш насны иргэд 3.39 дүнгээр бусад насны бүлгээс илүүтэйгээр сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлжээ. Хүйсийн хувьд эрчүүдэд дээрх үзүүлэлт 3.19 байхад эмэгтэйчүүдэд 3.12 байна.

3.2.2 Боловсрол соёл, спорт

Сүүлийн нэг жилийн хугацаанд танай хүүхэд төрийн өмчийн ЕБС, цэцэрлэгт хамрагдсан уу? гэсэн асуултад эцэг эх, асран хамгаалагчдын 73.1 хувь нь Боловсролын салбарын үйл ажиллагааг ЕБС-ын сургалтын орчин нөхцөл, сургалтын материал, сургалтын чанар, багш нарын үр чадвар болон цэцэрлэгийн багш нарын үр чадвараар үнэлсэн байна. Иргэд орон нутаг дахь ЕБС-ийн (4.22) болон цэцэрлэгийн багш нарын үр чадварт (4.15) сэтгэл ханамжтай байгааг судалгааны үр дүн харуулж байна.




Зураг 5. Боловсрол соёл, спортын салбарын үнэлгээ (n=1260)

Салбарын дундаж үнэлгээ 3.96 байгаа нь өөр бусад хүчин зүйлүүд болох чөлөөт цагаа өнгөрөөх газар, нийтийн биеийн тамирын байгууламжийн хүртээмж нөлөөлж байна. Энэ салбарын хүрээнд чөлөөт цагаа өнгөрөөх газарт анхаарал хандуулах шаардлагатай байгааг судалгааны үр дүн илтгэж байна.

Хүйсийн хувьд боловсрол соёл, спортын салбарын үнэлгээнд статистикийн хувьд ач холбогдлын түвшинд бодит ялгаа ажиглагдсангүй. Харин бага боловсролтой болон төрийн байгууллагад ажилладаг иргэд илүү сэтгэл ханамжтай байна.


3.2.3 Нийтийн тээвэр



Зураг 6. Нийтийн тээврийн салбарын үнэлгээ (n=570)

Судалгаанд хамрагдсан иргэдийн 66.9 хувь нь нийтийн тээврээр тогтмол үйлчлүүлдэггүй гэжээ. Нийтийн тээврийн салбарын үнэлгээ аймгийн түвшинд 3.56 байна. Энэ үзүүлэлт нь ерөнхийдөө иргэдийн ихэнх нь аймаг хот хоорондын нийтийр тээврээр тогтмол үйлчлүүлдэггүй, сумдад нийтийн тээвэр байхгүй, нийтийн тээврийн үйлчилгээ, маршрут, цагийн хуваарийн мөрдөлт, цас болон замын цэвэрлэгээ авто замын засвар шинэчлэлтэд сэтгэл ханамж дунд байгааг илтгэж байна.

3.2.4 Дэд бүтэц




Зураг 7. Дэд бүтцийн салбарын үнэлгээ (n=1185)

Иргэдийн 68.8 хувь нь миний амьдарч буй газар цахилгаан, ус, дулаанд холбогдсон гэж мэдээлсэн байна. Дэд бүтцийн салбарын үнэлгээнээс харахад цахилгаан болон халуун усны доголдол гардаг учраас 3.84 болон 3.28 гэсэн үнэлгээ өгчээ. Шөнийн тарифийн хөнгөлөлтөнд үзүүлэлт 2.67 байгаа нь иргэд төдийлэн сэтгэл ханамжгүй байна.

Цаашид дэд бүтцийн асуудлыг сайжруулахын тулд сүм аймгийг холбосон зам тавьж тоосжилтыг бууруулах (нүүрсний тээвэртэй холбоотой), бохир ус болон хог зайлуулах үйлчилгээнд илүүтэй анхаарал хандуулах шаардлагатай нь харагдаж байна. Дэд бүтцийн үнэлгээнд эмэгтэйчүүдээс илүү эрчүүд сэтгэл хангалуун байна. Мандал-Овоо, Цогтцэций, Ханбогд сумынхан хамгийн сэтгэл хангалуун бус байна.

3.2.5 Аюулгүй байдал шударга ёс

Өмнөговь аймгийн төв болон орон нутгийн сумдад эрүүл, аюулгүй амьдрах боломж, хууль дүрэм журам хэр зэрэг хангагдаж байгааг 5 үзүүлэлтийн хүрээнд иргэдээр үнэлүүлсэн байна. Хууль ёс, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаанд 3.53 гэсэн үнэлгээг өгсөн байгаа хэрэглэгч (иргэд) сэтгэл ханамж сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүд байгааг илэрхийлж байна.




Зураг 8. Аюулгүй байдал шударга ёсны салбарын үнэлгээ (n=1723)

Иргэд цагдаагийн 102 үйлчилгээ, түргэн шуурхай байдал, цагдаагийн албан хаагчдын харилцааны соёл, ёс зүйд дунджаас доогуур үнэлгээ өгчээ.

Судалгаанд оролцсон иргэдийн 38 хувь нь амьдарч буй орчин аюулгүй, 29.3 хувь нь гэрийн ойролцоо манай хүүхэд гадаа тоглоход аюулгүй гэж мэдээлжээ. Аюулгүй байдал шударга ёсны салбарын үзүүлэлт Даланзадгадын 5- р багт 3.58 буюу хамгийн өндөр үзүүлэлттэй гарчээ.

3.2.6 Хүнс, хөдөө аж ахуй




Зураг 9. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үнэлгээ (n=1723)

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааг 5 үзүүлэлтээр иргэдээр үнэлүүлээ. Салбарын дундаж үнэлгээ 3.08 гэж үнэлэгдсэн байна. Эдгээр үзүүлэлтүүдээс хамгийн сайн үнэлэгдсэн нь мал, махны худалдааны хүртээмж, үнэ байна. Дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж хүртээмж нь мал, махны худалдааны хүртээмж, үнэнээс арай доогуур үзүүлэлттэй байна.

ЖДҮХС – аас олгож буй зээлийн талаар мэдээлэл муу тул иргэд мэдэхгүйгээс гадна хүртээмж хангалтгүй учраас хамгийн бага үнэлгээ өгчээ гэж үзэж байна. Малчид мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг ч ихэвчлэн тогтмол хийгдэггүйтэй холбоотойгоор дундаж үнэлгээ авчээ.


3.2.7 Эрүүл орчин



Зураг 10. Эрүүл орчны салбарын үнэлгээ (n=1723)

Эрүүл орны чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагааг иргэд 3.64 гэсэн үнэлгээгээр үнэлсэн. Иргэд амьдарч буй орчноо агаар болон хөрсний бохирдол ихтэй гэж үзэж байгаа бөгөөд ногоон байгууламж хангалтгүй байгааг дурдсан байна. Орон нутгийн хүрээнд агаар, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг авах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх бүтээн байгуулалт, ажлыг эрчимжүүлэх хэрэгтэйг судалгааны үр дүн харуулж байна.


3.2.8 Ажил эрхлэлт, нийгмийн даатгал



Зураг 11. Ажил эрхлэлт, нийгмийн даатгалын салбарын үнэлгээ (n=1723)

Судалгаанд хамрагдсан орон нутгийн иргэд ажил эрхлэлт, нийгмийн даатгалын үйл ажиллагааг 3.22 гэж үнэлсэн байна. Иргэд нийгмийн даатгалд тогтмол хамрагдсанаар гарах ашиг, давуу талын талаар сайн мэдлэгтэй байна. Халамж тэтгэмж, зорилтот бүлэгтээ хүрч чаддаг эсэхэд эргэлзэж дунджаар 3.23 оноо өгсөн байна. Энэ үзүүлэлт шинээр гарч буй ажлын байрны талаарх мэдээллийн хүртээмжтэй адил түвшинд байна.


3.2.9 Татварын үйл ажиллагаа



Зураг 12. Татварын үйл ажиллагааны үнэлгээ (n=1723)

Татварын үйл ажиллагаанд иргэд 2.99 гэсэн үнэлгээ өгчээ. Татварын тодорхойлолт авах хүндрэл, бэрхшээл гэсэн үзүүлэлтэд 2.78 үнэлгээ авсан нь иргэдэд нэлээдгүй бэрхшээл тулгардаг бололтой. Мөн татварын ажилтнуудын харилцаа, ёс зүйд анхаарах шаардлагатайг судалгааны үр дүн нотолж байна. Ханбогд болон Даланзадгадын иргэд үнэлгээ бусад сумдынхаас доогуур байна.

3.2.10 Уул уурхайн үйл ажиллагаа




Зураг 13. Уул уурхайн үйл ажиллагааны үнэлгээ (n=1723)

Судалгаанд хамрагдсан иргэдийн хамгийн ихээр сэтгэл хангалуун бус байсан салбар нь уул уурхайн үйл ажиллагаа бөгөөд 12 салбар үзүүлэлтийн хамгийн бага үнэлгээг авсан байна. Дундаж үнэлгээ нь 2.84 байна. Цогтцэций, Ханбогд, Булган сумын иргэд уул уурхайн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус байна.

Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажил төдийлөн хийгддэггүй байна. Иймд байгаль орчны нөхөн сэргээлтийн ажилд Аймгийн Засаг даргын Тамгын газрын зүгээс хяналт хийх шаардлагатай байна.

3.2.11 Батлан хамгаалах




Зураг 14. Батлан хамгаалах салбарын үнэлгээ (n=1723)

Энэ оны 11 – р сард дөнгөж цэрэг татагдсан оюутан залуу нас барсан хэрэг гарсантай холбоотойгоор иргэд батлан хамгаалах салбарын үнэлгээнд төдийлөн сайн үнэлгээ өгсөнгүй. Мэдээлэл цуглуулах явц тухайн цаг үетэй давхацсан тул иргэд ийм үнэлгээ өгсөн байх магадлал өндөр байна.

Оюутан цэрэг хөтөлбөрийн үнэлгээ болон аймгийн штабын үйл ажиллагааны үнэлгээ ойролцоо буюу 2.83 ба 2.77 байна. Цэрэг татлагын үйл ажиллагаанд иргэд 2.94 үнэлгээг өгчээ.

3.2.12 Засаглал



Зураг 15. Засаглалын үнэлгээ (n=1723)

Хэрэглэгчийн үнэлгээгээр засаглалын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг 10 үзүүлэлтээр үнэлүүлэхэд иргэд аймгийн засаг дарга болон сумдын бодлого, үйл ажиллагаанд сэтгэл ханамж 3.49 үнэлгээ өгчээ. Энэ салбарын үзүүлэлт нийт 12 салбараас 5-д эрэмбэлэгдэж байна. **Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо** суманд засаглалын үзүүлэлт хамгийн өндөр буюу сайн үзүүлэлттэй байна.


Аймаг, сумын удирдлагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээх байдал 3.67 болон 3.62 байна. Дундаж үнэлгээтэй байгаа тул мэдээллийг зорилтот бүлгээс хамааран харилцан адилгүй сувгаар түгээх нь чухал юм. Хотын өнгө төрхөд иргэдээс хамгийн сайн үнэлгээг авсан байна.

3.3 ҮР ДҮН –ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖ

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг 1. төрийн үйлчилгээний чанар, 2. төрийн үйлчилгээний хүртээмж, 3. албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй, 4. төрийн байгууллагын орчин гэсэн 4 багц бүхий 19 үзүүлэлтээр үнэлэв.


3.3.1 Төрийн үйлчилгээний чанар

Судалгаанд хамрагдсан иргэд төрийн үйлчилгээний чанарыг 4.12 буюу сайн гэж үнэлсэн байна. Үүнээс харахад иргэд төрийн үйлчилгээний талаар санал гомдлоо, илэрхийлэх боломж бүрдсэн, хариу мэдээлэл өгөх байдал хангалттай түвшинд мөн албан хаагчдын ажлын бүтээмж өндөр, мэдлэг ур чадвартай хэмээн үнэлсэн байна.



Зураг 16. Төрийн үйлчилгээний чанарын үнэлгээ (n=1723)


3.3.2 Төрийн үйлчилгээний хүртээмж



Зураг 17. Төрийн үйлчилгээний хүртээмжийн үнэлгээ (n=1723)

Судалгаанд хамрагдсан иргэд төрийн үйлчилгээний хүртээмжийг 4.19 буюу сайн гэж үнэлсэн байна. Төрийн үйлчилгээний хүртээмж нь үйлчилгээний ачаалал, бүрдүүлэх материалын ойлгомжтой байдал, мэдээллийн хангалттай байдал, асуудлын хүрээнд мэдээлэл, зөвлөгөө авах боломжтой байх зэрэг 4 үзүүлэлтээс бүрдэж байгаа юм. Эдгээр бүх үзүүлэлтүүдэд иргэд сэтгэл ханамжтай байгаагаас гадна үйлчилгээг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх зэрэг энгийн ойлгомжтой байдал нь их таалагджээ. Сумын иргэдийн хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөө авах боломжтой байдал нь 4.21 буюу өндөр үзүүлэлттэй байна.

3.3.3 Төрийн үйлчилгээний албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй




Зураг 18. Төрийн үйлчилгээний албан хаагчийн харилцааны

соёл, ёс зүйн үнэлгээ (n=1723)

Төрийн ажилтнуудын иргэдэд туслах хандлага, эерэг таатай харилцаа, хариуцлагатай байдал, асуудлыг шийдвэрлэх байдал, ижил тэгш харилцаа хандлагыг гаргах зэрэг үзүүлэлтэд сайн гэсэн үнэлгээг өгсөн байна

Судалгаанд хамрагдсан иргэд төрийн албан хаагчийн харилцааны соёл, ёс зүйг үнэлэхэд албан хаагчдын шударга байдал бага үнэлгээтэй гарсан байна. Судалгааны энэхүү үзүүлэлтийн асуумж нь иргэд ойлгож хариулахад хоёрдмол утгыг илэрхийлж байгаа тул үзүүлэлт бага гарах үндэслэлийг бий болгож байна.

3.3.4 Төрийн байгууллагын орчин



Зураг 19. Төрийн байгууллагын орчны үнэлгээ (n=1723)

Иргэд төрийн байгууллагын орчныг 4 үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн бөгөөд дундаж үнэлгээ 4.20 буюу сайн гэж үнэлэгдсэн байна. Өөрийн орон нутгийн төрийн байгууллагын гадна доторх тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтой харагдахуйц гэж үзэж байна. Мөн хүлээлгийн танхим, шаардлагатай маягт бал үзэг хангалттай байдаг хэмээн үнэлсэн бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх дээр бусад үзүүлэлтээс бага үнэлгээг өгсөн байна.

3.3.5 Хамгийн сүүлд авсан үйлчилгээ, үйлчилгээний төрөл

Хүснэгт 3. Иргэдийн хамгийн сүүлд авсан төрийн үйлчилгээ


№	Үзүүлэлт	Давтамж	Эзлэх хувь
---	----------	---------	------------

1	Үйлчилгээний төрөл	Шууд үйлчилгээ авах	666	38.7%
		Лавлагаа, тодорхойлолт авах	797	46.3%
		Мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмж авах	269	15.6%
		Өргөдөл гомдол, санал хүсэлт өгөх	174	10.1%
		Зуучлах (авах гэж буй үйлчилгээтэй холбоотой материалуудаа бүрдүүлээд өгөх, төрийн ажилтан нь түүнийг хэлтэстээ хүргэх, буцаан олгох гэх мэт)	56	3.3%
		Бусад	237	13.8%

Төрийн байгууллагаас иргэдийн 46.3 хувь нь лавлагаа, тодорхойлолт авах, 38.7 хувь нь шууд үйлчилгээ авах, 15.6 хувь нь мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмж авах, 10.1 хувь нь өргөдөл гомдол, санал хүсэлт өгөх, 3.3 хувь нь зуучлах, 13.8 нь өөр бусад үйлчилгээ авсан байна.

Иргэд хамгийн сүүлд авсан үйлчилгээний төрлийг нэрлэхдээ багийн засаг даргын тодорхойлолт, e- Mongolia с тодорхойлолт, тоон гарын үсэг, гадаад паспорт, иргэний үнэмлэх, эмнэлгээр үйлчлүүлсэн үүнд эрт илрүүлэг орно, халамж, хүүхдийн мөнгө, цалинтай ээж, газрын гэрчилгээ, нүүрсний талон, шилжилт хөдөлгөөн, улсын бүртгэлийн газар, тэтгэвэр тогтоолгох, татвар гэх мэтийг дурдсан байна.

3.3.6 Хүссэн үйлчилгээгээ авч чадсан эсэх



Зураг 20. Иргэд хүссэн үйлчилгээгээ авч чадсан эсэх


Судалгаанд хамрагдсан иргэдийн 61.38 хувь нь үйлчлүүлсэн төрийн байгууллагаасаа хүссэн үйлчилгээгээ бүрэн авсан бол 38.62 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадаагүй байна.

3.3.7 Түргэн шуурхай байдал, хүнд суртал



Зураг 21. Иргэд төрийн үйлчилгээ авахын тулд ирэх давтамж

Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 42.1 хувь нь нэг төрлийн үйлчилгээ авахын тулд төрийн байгууллагаар 1 удаа, 30.6 хувь нь 2 удаа, 23.3 хувь нь 3-4 удаа, 4.0 хувь нь 5-аас дээш удаа ирэх шаардлагатай болсон гэж мэдээлжээ. Иргэдийн 57.9 хувь нь 2 болон түүнээс дээш удаа ирж үйлчлүүлжээ.



Зураг 22. Төрийн үйлчилгээ авахын тулд дамжин орох байгууллагын тоо

Нэг удаа үйлчилгээ авахдаа иргэдийн 46.8 хувь нь 1 байгууллагаа, 29.8 хувь нь 2, 15.8 хувь нь 3, 4.8 хувь нь 4 болон түүнээс дээш байгууллагаар дамжин орж үйлчилгээгээ авчээ.


3.3.8 Төрийн байгууллагын үйлчилгээний мэдээллийг авах эх сурвалж

Иргэд төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг тухайн байгууллагын веб сайт, интернэтээс авахыг илүүд үзэж байна. Харин үүний дараагаар тухайн телевиз болон нэг цэгийн үйлчилгээний ажилчдаас авахыг илүүд үзжээ.

Хүснэгт 4. Төрийн байгууллагын үйлчилгээний мэдээллийг авах хялбар эх сурвалж

№	Үзүүлэлт	Давтамж	Эзлэх хувь	
1	Үйлчилгээний мэдээллийн төрөл	Телевиз	533	30.9%
		Интернэт, тухайн байгууллагын вэб сайт	1188	68.9%
		Мэдээллийн самбар, зурагт хуудас	205	11.9%
		Гарын авлага, тараах материал	150	8.7%
		Хэвлэл, сонин	101	5.9%
		Төрийн байгууллагын мэргэжилтнүүд	301	17.5%
		Нэг цэгийн үйлчилгээний ажилчдаас	437	25.4%
		Бусад	64	3.7%

3.3.9 Төрийн албан хаагчийн мэдээллийн нээлттэй байдал



Зураг 23. Төрийн байгууллагын албан хаагчийн нэр, албан тушаал, хаягжилтын нээлттэй байдал

Иргэдийн үйлчлүүлсэн төрийн байгууллагын албан хаагчийн нэр, албан тушаал, хаягжилтын талаар асуухад 49.53 хувь бүх мэдээлэл бүрэн байсан, 44.67 хувь нь зарим мэдээлэл байсан, 5.80 хувь нь мэдээлэл огт байгаагүй гэж хариулжээ.


Иргэдээс орон нутагт тулгамдсан, нэн даруй анхаарал хандуулах ямар асуудлууд байгаа эсэхийг иргэдээс нээлттэй байдлаар тодруулахад 1. Цөлжилт, хуурайшилт ихсэж агаарын бохирдол, тоосжилт нэмэгдэж (

бэлчээрийн даац хэтрэн хөрсний доройтол) байгаа тул байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг байгаль орчинд чиглэсэн үйл ажиллагаа явуулах; 2. Ажлын байр бий болгох 3. Үнийн өсөлт, 4. Дулааны цахилгаан станц барих; 5. Аймаг сум хооронд зам тавих, дэд бүтцийг сайжруулах, 6. Хүүхэд тоглох тоглоомын талбай, чөлөөт цагаа өнгөрөөх газар шаардлагатай гэж үзжээ.

2023 онд хийгдсэн хамгийн үр дүнтэй ажлаар:

1. Өмнөговь аймгийн ИТХ-аар батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны Нутгийн Хишиг хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд хатуу хучилттай авто замын ажлууд
2. Айлын орон сууцны барилга, гэрэлтүүлэг
3. Эрүүл мэндийн төвийн барилгыг нэрлэжээ.
4. Төрийн албан хаагчдад зориулсан “Нутгийн дэм” хөтөлбөр

3.4 ҮР ДҮН – САЛБАР, ЧИГ ҮҮРГИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ




Зураг 24. Салбар чиг үүргийн дундаж үнэлгээ, салбар тус бүрээр

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны салбарын чиг, үүргийн дундаж үнэлгээг Зураг 24-т салбар тус бүрээр харуулав. Үр дүнгийн анализаас харахад салбарын дундаж үнэлгээ 2.96 - аас 3.37 хүртэл хэлбэлзэж дундаж үнэлгээ 3.37 байна. Судалгаагаар эрүүл мэнд болон боловсрол, соёл, спортын салбарын үнэлгээ иргэдээс “сайн” гэсэн үнэлгээ авсан байна. Эрүүл мэндийн салбарын хувьд эмнэлгийн

ачаалал, эмнэлгийн үйлчилгээний чанар, эмнэлгийн дотоод орчны тав тухтай байдалд иргэд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж өндөр үнэлгээ өгчээ. Боловсролын салбарын үйл ажиллагаанд ЕБС-ын сургалтын орчин нөхцөл, сургалтын материал, сургалтын чанар, багш нарын үр чадвар болон цэцэрлэгийн багш нарын үр чадвар гэсэн 4 үзүүлэлт сайн гэсэн үнэлгээг эцэх эх, асран хамгаалагчдаас авчээ.

Иргэдийн үнэлгээгээр хамгийн муу салбараар уул уурхайн үйл ажиллагаа 2.84 -аар үнэлэгджээ. Газрын доройтол, цөлжилтөөс хамгаалах нөхөн сэргээх чиглэлийн үйл ажиллагаа хангалтгүй буюу 2.69 байна. Иймээс Орон нутгийн онцлогоос шалтгаалсан уул уурхайн үйл ажиллагаа нь газрын хөрс, газрын нөхөн төлжилтийг үгүй болгож байгаа тул сэргээх, нөхөн төлжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. Ажлын байрны сонгон шалгаруулалтын шударга байдалд 2.75 гэсэн үнэлгээ өгчээ. Үүнд нутгийн иргэд сэтгэл ханамж муу байна.



Зураг 25. Салбар чиг үүргийн дундаж үнэлгээ, сумаар


Салбар чиг, үүргийн дундаж үнэлгээг сумдаар харьцуулахад Даланзадгадын 5 болон 8 – р баг, Цогт-Овоо сумын үзүүлэлт сайн гэсэн үнэлгээтэй байна. Ханбогд сум хамгийн бага үнэлгээтэй байна.

3.5 ҮР ДҮН – ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээ нь 4.15 буюу сайн түвшинд байна.

Судалгаанд хамрагдсан иргэд төрийн үйлчилгээний чанарыг 4.12 буюу сайн гэж үнэлсэн байна. Үүнээс харахад иргэд төрийн үйлчилгээний талаар санал гомдлоо, илэрхийлэх боломж бүрдсэн, хариу мэдээлэл өгөх байдал хангалттай түвшинд мөн албан хаагчдын ажлын бүтээмж өндөр, мэдлэг үр чадвартай хэмээн үнэлсэн байна.

Төрийн үйлчилгээний хүртээмжийг 4.19 буюу сайн гэж үнэлсэн байна. Төрийн үйлчилгээний хүртээмж нь үйлчилгээний ачаалал, бүрдүүлэх материалын ойлгомжтой байдал, мэдээллийн хангалттай байдал, асуудлын хүрээнд мэдээлэл, зөвлөгөө авах боломжтой байх зэрэг 4 үзүүлэлтээс бүрдэж байгаа юм. Эдгээр бүх үзүүлэлтүүдэд иргэд сэтгэл ханамжтай байгаагаас гадна үйлчилгээг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх зэрэг энгийн ойлгомжтой байдал нь их таалагджээ.




Хүснэгт 5. Салбар, чиг үүрэг болон үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээ, ерөнхий үнэлгээ, сумаар

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДЗ 1-р баг	ДЗ 2-р баг	ДЗ 3-р баг	ДЗ 4-р баг	ДЗ 5-р баг	ДЗ 6-р баг	ДЗ 7-р баг	ДЗ 8-р баг	Баян-Овоо	Булган	Гурвантэс	Мандал-Овоо	Манлай	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хурман	Цогт-Овоо	Цогтцэцэй	Номгон	Аймаг
1	Эрүүл мэнд	3.91	4.04	3.69	3.81	4.24	3.63	3.88	4.80	4.06	4.17	4.49	4.29	4.01	4.27	3.84	4.19	4.17	4.25	3.70	4.02	3.99
2	Боловсрол, соёл, спорт	4.03	4.04	3.86	3.77	4.42	3.89	3.95	4.75	3.98	4.04	4.19	3.29	4.10	4.45	3.60	4.15	4.38	4.42	3.50	4.10	3.96
3	Нийтийн тээвэр	3.68	3.88	3.05	3.39	4.67	3.29	3.52	4.67	3.76	3.28	4.20	2.13	3.34	3.85	2.93	3.27	2.74	4.48	3.74	3.15	3.56
4	Дэд бүтэц	3.20	3.74	3.50	2.82	4.59	3.30	3.44	4.61	3.71	2.93	3.53	2.68	3.13	3.45	2.74	3.73	3.34	3.42	2.77	3.33	3.31
5	Аюулгүй байдал, шударга ёс	3.49	3.63	3.23	3.51	4.45	3.34	3.44	4.50	3.91	4.16	4.10	3.81	3.16	3.94	2.91	3.93	3.68	3.80	2.88	3.61	3.53
6	Хүнс, хөдөө аж ахуй	2.80	3.27	2.97	2.67	3.67	2.71	2.84	3.89	3.72	3.40	3.55	3.28	2.77	3.79	2.42	3.81	3.58	3.36	2.85	3.19	3.08
7	Эрүүл орчин	3.65	3.66	3.45	3.53	4.06	3.27	3.50	4.27	4.18	4.07	4.09	4.49	3.68	4.37	3.17	4.13	4.19	4.37	2.63	3.74	3.64
8	Ажил эрхлэлт, нийгмийн даатгал	3.37	3.34	2.62	2.80	3.47	2.94	2.76	4.24	3.86	3.60	4.17	3.30	2.82	3.53	2.57	3.78	3.83	3.49	2.86	3.28	3.22
9	Татварын үйл ажиллагаа	2.81	3.31	2.83	2.39	2.89	2.65	2.62	4.01	3.45	3.15	3.58	3.01	2.96	3.45	2.33	3.34	3.37	3.33	2.86	3.60	2.99
10	Уул уурхай үйл ажиллагаа	2.88	3.13	2.78	2.43	3.26	2.61	2.74	3.87	3.64	2.11	3.40	2.87	2.46	3.11	2.52	3.01	2.78	2.63	2.43	3.21	2.84
11	Батлан хамгаалах	2.71	3.47	2.24	2.71	3.76	2.46	2.85	4.04	3.15	3.46	3.85	1.92	2.37	2.95	1.81	3.01	3.19	3.07	2.73	3.34	2.85
12	Засаглал	3.86	3.88	3.37	3.38	4.35	3.54	3.48	4.20	3.94	3.86	3.52	3.59	3.55	4.16	2.36	4.19	4.05	4.27	2.63	3.79	3.49
I	САЛБАР ЧИГ ҮҮРГИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ	3.37	3.62	3.13	3.10	3.99	3.14	3.25	4.32	3.78	3.52	3.89	3.22	3.20	3.78	2.77	3.71	3.61	3.74	2.96	3.53	3.37
1	Үйлчилгээний чанар	3.97	4.05	3.89	4.07	4.53	3.89	4.03	4.71	4.08	4.39	4.47	4.22	4.16	4.57	4.01	4.35	4.50	4.56	3.50	4.34	4.12
2	Үйлчилгээний хүртээмж	4.04	4.12	3.96	4.20	4.63	3.91	4.14	4.77	4.17	4.40	4.56	4.49	4.28	4.65	4.04	4.50	4.50	4.61	3.64	4.22	4.19
3	Албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй	4.04	4.03	3.95	4.02	4.47	3.86	4.12	4.77	4.10	4.23	4.09	4.23	4.18	4.59	3.98	4.52	4.58	4.61	3.68	4.05	4.09
4	Төрийн байгууллагын орчин	4.07	4.23	3.92	4.13	4.62	4.06	4.23	4.82	4.32	4.44	4.63	4.59	4.32	4.70	3.79	4.36	4.57	4.43	3.67	4.27	4.20
II	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ	4.03	4.11	3.93	4.11	4.56	3.93	4.13	4.77	4.17	4.37	4.44	4.38	4.23	4.63	3.96	4.43	4.54	4.55	3.62	4.22	4.15
III	ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ	3.70	3.86	3.53	3.60	4.27	3.53	3.69	4.54	3.97	3.94	4.16	3.80	3.71	4.20	3.36	4.07	4.07	4.15	3.29	3.87	3.76
IV	САЛБАР ЧИГ ҮҮРГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ (%)	47.1	50.6	43.8	43.4	55.8	43.9	45.5	60.5	52.9	49.3	54.5	45.1	44.7	52.9	38.7	52.0	50.5	52.4	41.5	49.4	47.2
V	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ (%)	24.2	24.6	23.6	24.6	27.4	23.6	24.8	28.6	25.0	26.2	26.6	26.3	25.4	27.8	23.7	26.6	27.2	27.3	21.7	25.3	24.9
VI	ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ (% нийлбэр)	71.3	75.3	67.4	68.0	83.2	67.5	70.3	89.1	77.9	75.5	81.1	71.4	70.1	80.6	62.5	78.6	77.7	79.7	63.2	74.7	72.1

Хүснэгт 6. Салбар, чиг үүрэг болон үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээ, ерөнхий үнэлгээ, судалгааны оролцогчдын шинжээр

№	ҮЗҮҮЛЭЛТ	ХҮЙС		НАСНЫ БҮЛЭГ						БОЛОВСРОЛЫН ТҮВШИН							АЖИЛ ЭРХЛЭЛТ						
		Эрэгтэй	Эмэгтэй	24 хүртэл	25-34 нас	35-44 нас	45-54 нас	55-64 нас	65 - аас дээш	Боловсролгүй	Бага	Сурь	Бүрэн дунд	Техник болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн	Дээд	Ажилгүй	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Олон улсын байгууллага	Хувийн хэвшил,	Хувцараа бизнес	Тэтгэвэр
1	Эрүүл мэнд	4.04	3.97	4.05	3.91	3.91	4.08	4.12	4.26	4.10	4.16	4.11	3.91	4.03	4.12	3.96	3.91	4.02	3.92	4.10	3.91	4.04	4.17
2	Боловсрол, соёл, спорт	3.97	3.95	3.94	3.95	3.96	3.96	3.98	4.03	4.06	4.20	3.82	3.90	4.06	3.99	3.99	3.89	4.11	3.96	3.96	3.85	3.90	3.96
3	Нийтийн тээвэр	3.67	3.50	3.59	3.44	3.53	3.75	3.64	3.74	3.95	3.79	3.53	3.61	3.67	3.58	3.44	3.59	3.41	3.46	2.96	3.58	3.73	3.68
4	Дэд бүтэц	3.42	3.25	3.44	3.24	3.24	3.23	3.53	3.55	3.88	3.33	3.12	3.32	3.46	3.24	3.30	3.21	3.35	3.31	3.16	3.29	3.25	3.47
5	Аюулгүй байдал, шударга ёс	3.63	3.48	3.66	3.48	3.44	3.52	3.75	3.65	3.83	3.73	3.61	3.44	3.54	3.57	3.54	3.34	3.73	3.58	3.60	3.45	3.37	3.65
6	Хүнс, хөдөө аж ахуй	3.23	3.00	3.24	3.06	2.94	3.12	3.15	3.35	3.85	3.22	3.19	2.96	3.10	3.28	3.04	2.91	3.19	3.01	1.78	3.04	3.14	3.14
7	Эрүүл орчин	3.66	3.62	3.65	3.50	3.61	3.72	3.88	3.85	4.02	3.94	3.74	3.48	3.73	3.64	3.65	3.55	3.75	3.58	3.59	3.48	3.54	3.80
8	Ажил эрхлэлт, нийгмийн даатгал	3.31	3.18	3.45	3.28	3.15	3.30	3.13	2.81	3.34	3.03	3.09	3.07	3.16	3.18	3.42	2.98	3.57	3.19	3.78	3.27	3.08	2.93
9	Татварын үйл ажиллагаа	3.09	2.93	3.09	3.01	3.02	2.98	2.87	2.84	3.63	2.74	2.70	2.93	2.98	2.99	3.13	2.71	3.16	3.04	2.79	2.98	3.16	2.84
10	Уул уурхай үйл ажиллагаа	3.07	2.71	3.33	2.82	2.68	2.92	2.75	2.85	3.73	2.51	2.76	2.78	2.84	3.15	2.85	2.70	2.87	2.93	2.25	2.92	2.91	2.72
11	Батлан хамгаалах	3.24	2.63	3.02	2.79	2.71	2.99	2.89	3.13	3.60	2.85	2.86	2.70	2.74	3.11	2.89	2.58	3.00	2.82	3.25	2.78	2.81	2.87
12	Засаглал	3.54	3.46	3.59	3.35	3.38	3.55	3.82	3.83	3.97	3.60	3.35	3.30	3.53	3.56	3.61	3.18	3.78	3.28	3.38	3.35	3.23	3.79
I	САЛБАР ЧИГ ҮҮРГИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ	3.49	3.31	3.51	3.32	3.30	3.43	3.46	3.49	3.83	3.42	3.32	3.28	3.40	3.45	3.40	3.21	3.50	3.34	3.22	3.33	3.35	3.42
1	Үйлчилгээний чанар	4.19	4.09	4.18	4.08	4.06	4.11	4.20	4.45	4.39	4.34	4.17	4.02	4.14	4.15	4.13	4.04	4.25	4.08	3.75	4.04	4.00	4.27
2	Үйлчилгээний хүртээмж	4.22	4.18	4.21	4.13	4.15	4.22	4.30	4.48	4.28	4.40	4.21	4.12	4.22	4.20	4.21	4.13	4.30	4.13	4.03	4.11	4.06	4.34
3	Албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй	4.13	4.07	4.11	4.03	4.05	4.11	4.18	6.54	4.19	4.25	4.15	4.04	4.03	4.12	4.09	6.08	4.22	4.02	3.92	3.95	3.96	4.24
4	Төрийн байгууллагын орчин	4.24	4.18	4.29	4.11	4.14	4.25	4.30	4.51	4.30	4.45	4.22	4.17	4.19	4.21	4.18	4.17	4.27	4.18	4.00	4.12	4.06	4.36
II	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ	4.19	4.13	4.20	4.09	4.10	4.17	4.25	4.99	4.29	4.36	4.19	4.09	4.14	4.17	4.15	4.60	4.26	4.10	3.92	4.06	4.02	4.30
III	ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ	3.84	3.72	3.85	3.70	3.70	3.80	3.85	4.24	4.06	3.89	3.76	3.68	3.77	3.81	3.78	3.91	3.88	3.72	3.57	3.69	3.68	3.86
IV	САЛБАР ЧИГ ҮҮРГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ (%)	48.8	46.3	49.1	46.4	46.1	48.0	48.4	48.9	53.6	47.9	46.5	46.0	47.7	48.3	47.6	45.0	48.9	46.7	45.0	46.6	46.8	47.9
V	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ (%)	25.2	24.8	25.2	24.5	24.6	25.0	25.5	30.0	25.7	26.2	25.1	24.5	24.9	25.0	24.9	27.6	25.6	24.6	23.5	24.3	24.1	25.8
VI	ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ (% нийлбэр)	74.0	71.1	74.3	71.0	70.7	73.0	73.9	78.8	79.3	74.1	71.7	70.5	72.5	73.3	72.5	72.6	74.5	71.4	68.6	70.9	71.0	73.7

Зураг 26. Үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээ



Зураг 27. Үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээ, сумаар

Сумын иргэдийн хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөө авах боломжтой байдал нь 4.21 буюу өндөр үзүүлэлттэй байна.

Төрийн ажилтнуудын иргэдэд туслах хандлага, эерэг таатай харилцаа, хариуцлагатай байдал, асуудлыг шийдвэрлэх байдал, ижил тэгш харилцаа хандлагыг гаргах зэрэг үзүүлэлтэд сайн гэсэн үнэлгээг өгсөн байна.

Иргэд төрийн байгууллагын орчныг 4 үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн бөгөөд дундаж үнэлгээ 4.2 буюу сайн гэж үнэлэгдсэн байна. Өөрийн орон нутгийн төрийн байгууллагын гадна доторх тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтой харагдахуйц гэж үзэж байна. Мөн хүлээлгийн танхим, шаардлагатай маягт бал үзэг хангалттай байдаг хэмээн үнэлсэн бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх дээр бусад үзүүлэлтээс бага үнэлгээг өгсөн байна.


Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээг сум, баг гэсэн 20 талбараар харьцуулахад 7 сум, баг маш сайн, 10 нь сайн, 3 нь дунджаас доогуур үнэлгээ авсан байна.


3.6.ҮР ДҮН –ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Ерөнхий үнэлгээг салбар, чиг үүргийн дундаж үнэлгээ болон үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээ хоёрын нийлбэрээр тооцох ба салбарын үнэлгээ 70 хувь, үйлчилгээний үнэлгээ 30 хувийг эзэлнэ. Үүний дагуу Өмнөговь аймгийн ЗДТГ-ын ерөнхий үнэлгээг нийт сумдаар болон судалгаанд хамрагдсан иргэдийн хүйс, насны бүлэг, боловсрол, ажил эрхлэлтээр ангилан боловсруулалтыг хийж гүйцэтгэв (Хүснэгт 5, 6).

Аймгийн ЗДТГ болон сумын үйл ажиллагаанд өгөх иргэдийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ 3.76 буюу иргэдийн сэтгэл ханамж сайн бөгөөд Даланзадгадын 5 болон 8 – р баг, Баян-Овоо, Номгон, Гурвантэс, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сум иргэд маш сайн болон сайн үнэлгээтэй байна. Нөгөө талаар салбар чиг үүргийн хүрээнд анхаарах шаардлагатай зарим зүйл байгааг илэрхийлнэ. Уул уурхай үйл ажиллагаа явуулдаг Ханбогд болон Цогтцэций сумынхан аймгийн ерөнхий үнэлгээнээс харьцангуй бага буюу иргэд сэтгэл ханамжтай бус байна.

Зураг 23. Аймгийн ерөнхий үнэлгээ, сумаар





Зураг 23. Аймгийн ерөнхий үнэлгээ, судалгаанд хамрагдсан оролцогчдын шинжээр

Төрийн байгууллагад ажилладаг иргэд салбар болон төрийн үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдалд илүү сэтгэл ханамжтай байгаа бол олон улсын байгууллагад ажилладаг иргэд хамгийн бага, хувийн хэвшил болон хувиараа бизнес эрхэлдэг иргэдийн сэтгэл ханамж дунджаас доогуур байна

Хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэйчүүдийн сэтгэл ханамж эмэгтэйчүүдээс 0.13 пунктээр илүү байна. Насны бүлгээр 24 нас хүртэлх залуучууд болон 65- аас дээш насныхан сэтгэл ханамж өндөртэй байгаа бол 34-44 насны иргэдийн сэтгэл ханамж хамгийн бага байна. Боловсролгүй болон бага боловсролтой иргэд боловсрол өндөртэй иргэдээс илүү сэтгэл ханамжтай байна.

4. ДҮГНЭЛТ

1. Судалгааг Өмнөговь аймгийн 13 сумд зохион байгуулсан ба нийт 1723 иргэнийг боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал, орлогын түвшин зэргийг харгалзан судалгаанд түүвэрлэн хамруулсан. Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд 18- аас 90 насны хоорондох төлөөлөл хамрагдсан ба хүйсийн хувьд 64.7 хувь нь эмэгтэй, 35.3 хувь нь эрэгтэй байлаа. Харин боловсролын хувьд 38.1 хувь дээд боловсролтой, 27.8 хувь

- бүрэн дунд боловсролтой иргэд хамрагдсан бол ажил эрхлэлтийн хувьд бүх салбарт ажиллаж байгаа иргэдийн төлөөллийг хамруулсан болно. Иргэдийн 67.3 хувь нь 1.500.000 хүртэлх төгрөгийн орлоготой байна.
- Иргэд, гэр бүлийн өрхийн орлого өнгөрсөн жилийн хугацаанд **28.26** хувь буюу судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 4 хүн тутмын нэг нь өрхийн амьжиргаа мэдэгдэхүйц болон бага зэрэг дээшилсэн гэж мэдээлжээ.
 - Ерөнхий үнэлгээ:** Аймгийн ЗДТГ болон сумын үйл ажиллагаанд өгөх иргэдийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ **3.76** буюу иргэдийн сэтгэл ханамж сайн боловч Даланзадгадын 5 болон 8 – р баг, Баян-Овоо, Номгон, Гурвантэс, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сумын иргэд маш сайн болон сайн үнэлгээтэй байна. Уул уурхай үйл ажиллагаа явуулдаг Ханбогд болон Цогтцэций сумынхан аймгийн ерөнхий үнэлгээнээс харьцангуй бага буюу иргэд сэтгэл ханамжтай бус байна.
 - Төрийн байгууллагад ажилладаг иргэд салбар болон төрийн үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдалд илүү сэтгэл ханамжтай байгаа бол олон улсын байгууллагад ажилладаг иргэд хамгийн бага, хувийн хэвшил болон хувиараа бизнес эрхэлдэг иргэдийн сэтгэл ханамж дунджаас доогуур байна.
 - Хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэйчүүдийн сэтгэл ханамж эмэгтэйчүүдээс 0.13 пунктээр илүү байна. Насны бүлгээр 24 нас хүртэлх залуучууд болон 65- аас дээш насныхан сэтгэл ханамж өндөртэй байгаа бол 34-44 насны иргэдийн сэтгэл ханамж хамгийн бага байна. Боловсролгүй болон бага боловсролтой иргэд боловсрол өндөртэй иргэдээс илүү сэтгэл ханамжтай байна.
 - Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны салбарын чиг, үүргийн дундаж үнэлгээ 2.96** - аас **3.37** хүртэл хэлбэлзэж дундаж үнэлгээ **3.37** байна. Судалгаагаар эрүүл мэнд болон боловсрол, соёл, спортын салбарын үнэлгээ иргэдээс “сайн” гэсэн үнэлгээ авсан байна. Эрүүл мэндийн салбарын хувьд эмнэлгийн ачаалал, эмнэлгийн үйлчилгээний чанар, эмнэлгийн дотоод орчны тав тухтай байдалд иргэд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж өндөр үнэлгээ өгчээ. Боловсролын салбарын үйл ажиллагаанд ЕБС-ын сургалтын орчин нөхцөл, сургалтын материал, сургалтын чанар, багш нарын ур чадвар болон цэцэрлэгийн багш нарын ур чадвар гэсэн 4 үзүүлэлт сайн гэсэн үнэлгээг эцэх эх, асран хамгаалагчдаас авчээ.
 - Иргэдийн үнэлгээгээр хамгийн муу салбараар уул уурхайн үйл ажиллагаа **2.84** -аар үнэлэгджээ. Газрын доройтол, цөлжилтөөс хамгаалах нөхөн сэргээх чиглэлийн үйл ажиллагаа хангалтгүй буюу **2.69** байна. Иймээс Орон нутгийн онцлогоос шалтгаалсан уул уурхайн үйл ажиллагаа нь газрын хөрс, газрын нөхөн төлжилтийг үгүй болгож байгаа тул сэргээх, нөхөн төлжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. Ажлын байрны сонгон шалгаруулалтын шударга байдалд **2.75** гэсэн үнэлгээ өгчээ.
 - Энэ оны 11 – р сард дөнгөж цэрэг татагдсан оюутан залуу нас барсан хэрэг гарсантай холбоотойгоор иргэд батлан хамгаалах салбарын үнэлгээнд төдийлөн сайн үнэлгээ өгсөнгүй. Мэдээлэл цуглуулах явц тухайн цаг үетэй давхацсан тул иргэд ийм үнэлгээ өгсөн байх магадлал өндөр байна. Оюутан цэрэг хөтөлбөрийн үнэлгээ болон аймгийн штабын

- үйл ажиллагааны үнэлгээ ойролцоо буюу **2.83** ба **2.94** байна. Цэрэг татлагын үйл ажиллагаанд иргэд **2.77** үнэлгээг өгчээ.
9. Салбар чиг, үүргийн дундаж үнэлгээг сумдаар харьцуулахад Даланзадгадын 5 болон 8 – р баг, Цогт-Овоо сумын үзүүлэлт сайн гэсэн үнэлгээтэй байна. Ханбогд сум хамгийн бага үнэлгээтэй байна.
 10. **Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээ** нь **4.1** буюу сайн түвшинд байна.
 11. Судалгаанд хамрагдсан иргэд төрийн үйлчилгээний чанарыг **4.12** буюу сайн гэж үнэлсэн байна. Үүнээс харахад иргэд төрийн үйлчилгээний талаар санал гомдлоо, илэрхийлэх боломж бүрдсэн, хариу мэдээлэл өгөх байдал хангалттай түвшинд мөн албан хаагчдын ажлын бүтээмж өндөр, мэдлэг үр чадвартай хэмээн үнэлсэн байна.
 12. Төрийн үйлчилгээний хүртээмжийг **4.1** буюу сайн гэж үнэлсэн байна. Төрийн үйлчилгээний хүртээмж нь үйлчилгээний ачаалал, бүрдүүлэх материалын ойлгомжтой байдал, мэдээллийн хангалттай байдал, асуудлын хүрээнд мэдээлэл, зөвлөгөө авах боломжтой байх зэрэг 4 үзүүлэлтээс бүрдэж байгаа юм. Эдгээр бүх үзүүлэлтүүдэд иргэд сэтгэл ханамжтай байгаагаас гадна үйлчилгээг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх зэрэг энгийн ойлгомжтой байдал нь их таалагджээ. Сумын иргэдийн хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөө авах боломжтой байдал нь **4.21** буюу өндөр үзүүлэлттэй байна.
 13. Төрийн ажилтнуудын иргэдэд туслах хандлага, эерэг таатай харилцаа, хариуцлагатай байдал, асуудлыг шийдвэрлэх байдал, ижил тэгш харилцаа хандлагыг гаргах зэрэг үзүүлэлтэд сайн гэсэн үнэлгээг өгсөн байна
 14. Иргэд төрийн байгууллагын орчныг 4 үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн бөгөөд дундаж үнэлгээ **4.2** буюу сайн гэж үнэлэгдсэн байна. Өөрийн орон нутгийн төрийн байгууллагын гадна доторх тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтой харагдахуйц гэж үзэж байна. Мөн хүлээлгийн танхим, шаардлагатай маягт бал үзэг хангалттай байдаг хэмээн үнэлсэн бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх дээр бусад үзүүлэлтээс бага үнэлгээг өгсөн байна.
 15. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн дундаж үнэлгээг сум, баг гэсэн **20** талбараар харьцуулахад **7** сум, баг маш сайн, **10** нь сайн, **3** нь дунджаас доогуур үнэлгээ авсан байна.

5. ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүн, тайланд үндэслэн дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Салбарын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамж дунд зэрэг байгаа тул сэтгэл ханамж доогуур үзүүлэлттэй байгаа эрүүл мэнд, боловсролоос бусад салбарт түлхүү анхаарч ажиллах, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх ажлыг төлөвлөн хийх
2. Иргэд төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид сэтгэл ханамжтай байгаа тул өнөөгийн нөхцөл байдлыг хадгалан илүү сайжруулахад анхаарал хандуулах

-
3. Иргэдэд аймаг, сумаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухайд хүргэх. Мэдээллийг зорилтот бүлгийн иргэд ашиглах боломжтой, өдөр тутамдаа ашигладаг мэдээллийн эх үүсвэрээр түгээх
 4. Ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд анхаарах. Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй орон нутагт газрын нөхөн төлжилтийн ажлуудыг хийх, хийгдэж буй ажилд хяналт тавих. Орон нутгийн иргэд агаар, хөрсний бохирдолд санаа зовниж байгаа тул энэ чиглэлээр бодитой үр дүн бүхий ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр хэрэгжиж буй ажлуудыг эрчимжүүлэх
 5. ОНХС, төсвийн зарцуулалт болон шийдвэр гарах үйл ажиллагаанд иргэдийн оролцоо болон хяналт тавих боломжийг нэмэгдүүлэхэд анхаарах
 6. Чөлөөт цаг өнгөрөөх газар буюу нийтийн биеийн тамирын байгууламж, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн зэрэг иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг нэмэгдүүлэхэд анхаарах
 7. Орон нутгуудад хүүхдэд ээлтэй, хүүхэд тоглоход аюулгүй байдлыг хангасан стандартад нийцсэн тоглоомын талбайг нэмэгдүүлэх
 8. Шинээр ажлын байр бий болгох, түүний талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх
 9. Татвар, газрын алба, цагдаагийн байгууллага зэрэг төрийн үйлчилгээний байгууллагуудын ил тод нээлттэй, тэгш хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх

Бүрэн дунд боловсролтой, 34-44 насныхан болон хувиараа бизнес эрхлэгчид болон хувийн хэвшилд ажилладаг иргэдийн зүгээс өгсөн үнэлгээ хамгийн бага байгаад анхаарч, цаашдыг бодлого, үйл ажиллагаанд эдгээр бүлгүүдийн онцлог хэрэгцээг илүү тусгаж байх

Хавсралт 1. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, салбарын үйлчилгээ болон сумаар

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДЗ 1-р баг	ДЗ 2-р баг	ДЗ 3-р баг	ДЗ 4-р баг	ДЗ 5-р баг	ДЗ 6-р баг	ДЗ 7-р баг	ДЗ 8-р баг	Баян-Овоо	Булган	Гурвантэс	Мандал-Овоо	Манлай	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогт-Овоо	Цогтцэций	Номгон	Аймаг
1. Эрүүл мэнд	“Эрт илрүүлэг” үзлэг, оношилгооны хүртээмж	3.40	3.98	3.67	3.18	3.67	3.19	3.80	4.72	4.07	4.24	4.43	4.41	4.03	3.78	3.43	3.84	3.89	4.36	3.31	3.47	3.71
	Эмнэлгийн ачаалал	3.67	3.95	3.71	3.92	4.03	3.56	3.64	4.75	4.03	3.96	4.36	4.05	3.85	3.95	3.90	4.03	3.67	4.11	3.65	4.07	3.89
	Эмнэлгийн үйлчилгээний чанар	4.06	4.14	3.81	4.10	4.69	3.70	4.02	4.79	4.17	4.24	4.53	4.43	4.10	4.61	3.93	4.51	4.28	4.50	3.93	4.18	4.14
	Эмнэлгийн дотоод орчны тав тух	4.37	4.27	4.15	4.52	4.90	4.19	4.42	4.92	4.24	4.72	4.58	4.68	4.38	4.61	4.10	4.68	4.56	4.83	3.95	4.33	4.37
	Түргэн тусламж 103-ийн үйл ажиллагаа	3.98	4.11	3.32	3.24	4.08	3.62	3.55	4.79	3.86	3.60	4.49	3.84	3.78	4.12	3.73	3.59	4.17	3.36	3.48	3.89	3.81
	Эмч эмнэлгийн ажилчдын харилцаа, ёс зүй	3.99	3.82	3.51	3.88	4.05	3.53	3.87	4.83	3.97	4.24	4.56	4.35	3.95	4.56	3.94	4.49	4.44	4.33	3.86	4.18	4.03
2. Боловсрол, соёл, спорт	ЕБС-ийн сургалтын орчин, нөхцөл, сургалтын материалын хангамж	4.20	4.13	4.01	3.93	4.39	4.04	4.38	4.93	4.18	4.29	4.28	4.29	4.07	4.68	4.02	4.28	4.58	4.57	3.72	4.05	4.16
	ЕБС-ийн сургалтын чанар	4.17	4.26	4.17	4.07	4.79	4.14	4.33	4.91	4.18	4.59	4.17	3.71	4.02	4.73	3.80	4.09	4.55	4.76	3.79	4.10	4.17
	ЕБС-ийн багш нарын үр чадвар	4.31	4.28	4.12	4.09	4.85	4.37	4.40	4.95	4.18	4.37	4.22	3.64	4.18	4.55	3.90	4.00	4.66	4.89	3.79	4.23	4.22
	Цэцэрлэгийн багш нарын чадвар	3.70	4.20	3.95	3.98	4.97	4.28	4.05	4.75	4.27	3.49	4.59	3.50	4.14	4.70	3.99	4.28	4.26	4.54	4.07	4.40	4.15
	Чөлөөт цагаа өнгөрөөх газар	3.78	3.64	3.61	3.68	3.78	3.54	3.45	4.64	3.63	3.66	3.92	2.67	4.03	4.33	3.13	3.91	3.81	4.00	2.71	4.00	3.60
	Урлаг соёлын үйлчилгээ	4.25	3.81	3.73	3.59	4.18	3.82	3.67	4.70	3.71	4.21	4.18	3.02	4.12	4.17	3.59	4.13	4.45	4.36	3.47	4.05	3.91
	Та болон танай гэр бүлийн гишүүд спортоор хичээллэдэг эсэх	4.03	4.03	3.48	3.50	4.08	3.54	3.71	4.55	4.00	3.74	4.08	2.65	4.09	3.72	3.47	4.13	4.14	3.96	4.01	3.93	3.83
	Нийтийн биеийн тамирын байгууламжийн хүртээмж	3.77	3.99	3.80	3.29	4.34	3.42	3.64	4.53	3.67	3.97	4.11	2.86	4.12	4.72	2.90	4.35	4.55	4.26	2.41	4.03	3.65
3. Нийтийн гэвэр	Нийтийн тээврийн тав тух	4.18	3.75	3.08	2.91	4.75	4.00	3.93	4.85	3.70	3.39	4.00	3.55	3.00	3.88	3.38	3.05	2.74	4.67	3.75	-	3.72
	Нийтийн тээврийн үйлчилгээний маршрут, цагийн хуваарь	4.17	4.22	3.53	2.88	4.75	3.85	3.33	4.73	4.00	3.29	4.00	3.82	3.07	4.12	3.57	2.95	2.22	4.72	3.61	-	3.73
	Нийтийн тээврийн үйлчилгээ маршрут, цагийн хуваарийн мөрдөлт	2.67	3.23	1.66	3.06	4.32	1.99	3.00	4.52	3.42	3.42	4.05	1.07	3.47	3.76	2.33	3.37	2.52	4.02	3.80	3.15	3.07
	Авто замын засвар, шинэчлэлт	3.69	3.89	3.44	3.91	4.88	3.30	3.58	4.60	3.96	3.06	4.36	1.05	3.62	3.91	2.65	3.57	3.29	4.52	3.81	-	3.61
	Цасны цэвэрлэгээ, замын хальтиргаа арилгах үйлчилгээ	3.71	4.30	3.55	4.18	4.64	3.33	3.77	4.62	3.71	3.26	4.61	1.16	3.53	3.59	2.74	3.40	2.95	4.46	3.71	-	3.64
4. Дэд бүтэц	Цахилгааны доголдол, тасалдал	4.22	4.48	3.90	2.82	4.78	4.07	3.96	4.64	3.97	3.88	3.53	3.09	3.92	4.46	3.20	4.43	3.93	4.21	3.43	3.80	3.84
	Халуун усны доголдол, тасалдал	2.77	3.80	3.40	2.62	4.47	3.06	3.24	4.66	3.69	2.60	3.68	3.66	3.39	3.59	2.76	3.89	3.33	4.03	2.80	3.35	3.28
	Шөнийн тарифын хөнгөлөлт	3.14	3.23	3.38	2.94	4.56	2.83	3.02	4.72	3.18	1.64	2.26	1.43	1.90	.62	2.21	2.89	2.24	2.09	2.06	2.28	2.67
	Бохир үс зайлуулах үйлчилгээ	2.06	2.96	2.87	2.09	4.42	2.59	2.80	4.42	3.83	3.05	4.08	2.72	2.99	3.96	2.47	3.52	3.55	2.42	2.48	3.26	2.98
	Хог зайлуулах үйлчилгээ	3.79	4.24	3.96	3.61	4.75	3.94	4.20	4.59	3.88	3.50	4.11	2.49	3.43	4.60	3.06	3.91	3.64	4.36	3.09	3.95	3.77

№	ҮЗҮҮЛЭЛТ																					
		ДЗ 1-р баг	ДЗ 2-р баг	ДЗ 3-р баг	ДЗ 4-р баг	ДЗ 5-р баг	ДЗ 6-р баг	ДЗ 7-р баг	ДЗ 8-р баг	Баян-Овоо	Булган	Гурвантэс	Мандал-Овоо	Манлай	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогт-Овоо	Цогтцэций	Номгон	Аймаг
5. Аюулгүй байдал, шударга сө	Хууль, дүрэм, журмын тэгш үйлчлэх байдал	3.17	3.39	2.97	3.34	4.15	3.12	3.14	4.47	3.48	3.55	3.85	3.60	2.94	3.49	2.79	3.72	3.50	3.78	2.90	3.60	3.33
	Орчны аюулгүй байдал	3.84	3.87	3.64	3.75	4.57	3.69	4.13	4.67	4.33	4.57	4.24	4.16	3.65	4.55	3.40	4.37	4.50	4.42	2.85	3.99	3.88
	Хүүхэд гадаа тоглох аюулгүй байдал	3.53	3.64	3.35	4.00	4.43	3.49	3.46	4.59	4.25	4.50	3.86	4.09	3.57	4.33	3.09	4.13	4.02	4.20	2.75	3.56	3.66
	Цагдаагийн 102-ийн үйлчилгээний түргэн шуурхай байдал	3.41	3.60	2.81	3.22	4.46	3.17	3.28	4.37	3.65	4.03	4.29	2.95	2.85	3.45	2.61	3.70	2.83	2.74	3.01	3.50	3.34
	Цагдаагийн албан хаагчдын харилцааны соёл, ёс зүй	3.48	3.67	3.36	3.22	4.62	3.24	3.17	4.38	3.85	4.12	4.25	4.23	2.76	3.87	2.64	3.76	3.52	3.88	2.87	3.40	3.47
6. Хүнс, хөдөө аж ахуй	ЖДҮХС-аас олгож буй зээлийн үйлчилгээ	2.33	2.99	2.71	2.03	3.11	2.22	2.32	3.92	3.48	2.81	3.58	2.93	3.00	3.18	1.69	3.41	3.14	2.78	2.33	2.97	2.68
	Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	2.50	3.17	2.81	2.36	2.71	2.06	2.91	3.82	3.85	3.45	3.89	3.28	3.21	4.60	2.14	4.04	3.71	3.26	2.28	3.28	2.93
	Мал, махны худалдааны хүртээмж, үнэ	3.06	3.49	3.04	3.14	4.60	3.08	3.32	3.95	3.69	3.66	3.48	3.42	2.74	3.76	2.85	3.98	3.62	3.74	3.54	3.13	3.36
	Дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж, хүртээмж	2.99	3.39	3.33	2.86	3.83	3.17	2.86	3.95	3.73	3.64	3.36	3.30	2.47	3.69	2.74	3.89	3.74	3.30	3.30	3.24	3.24
	Хүнсний аюулгүй байдал, хүртээмж	3.12	3.31	2.94	2.97	4.11	3.03	2.80	3.84	3.83	3.45	3.46	3.47	2.46	3.69	2.68	3.74	3.69	3.72	2.79	3.31	3.19
7. Эрүүл орчин	Агаарын бохирдол	3.52	3.49	3.33	3.57	3.77	3.28	3.12	4.15	4.19	4.17	4.04	4.56	3.68	4.35	3.25	4.33	4.14	4.40	2.30	3.75	3.56
	Хөрсний бохирдол	3.70	3.56	3.19	3.29	3.86	3.06	3.49	4.18	4.29	3.78	4.14	4.47	3.47	4.42	3.03	3.96	4.05	4.30	2.35	3.68	3.51
	Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн хүртээмж	3.27	3.30	3.26	3.14	3.98	2.80	3.10	4.29	3.98	3.69	3.59	4.09	3.29	3.91	2.81	3.98	4.12	3.92	2.25	3.44	3.30
	Цаг агаарын мэдээний хүртээмж	4.10	4.30	4.01	4.13	4.63	3.93	4.28	4.45	4.27	4.66	4.58	4.86	4.29	4.80	3.59	4.26	4.45	4.84	3.63	4.09	4.17
8. Ажил эрхлэлт, нийгмийн даатгал	Шинээр гарч буй ажлын байрны талаарх мэдээллийн хүртээмж	3.37	3.30	2.35	3.05	3.15	2.91	2.68	4.44	3.73	3.55	4.23	3.35	2.74	3.16	2.52	3.72	3.74	3.64	2.98	3.28	3.20
	Ажлын байрны нэмэгдэл	3.17	3.34	2.42	2.71	3.23	2.84	2.65	4.42	3.71	3.14	4.19	3.05	2.59	3.20	2.34	3.65	3.60	3.46	3.00	3.19	3.11
	Нийгмийн даатгалд тогтмол хамрагдсанаар гарах ашиг, давуу талын мэдлэг	3.42	3.27	2.92	2.57	4.48	3.12	2.84	4.07	3.92	4.24	4.24	3.53	2.79	3.85	2.80	4.09	4.00	3.80	2.74	3.21	3.36
	Халамж, тэтгэмж, зорилтот бүлэгтээ хүрч чаддаг эсэх	3.52	3.46	2.78	2.84	3.03	2.88	2.86	4.03	4.08	3.48	4.03	3.28	3.16	3.89	2.63	3.65	4.00	3.06	2.70	3.44	3.23
	НӨАТ-ын буцаан олголтын үйл ажиллагаа	3.21	3.51	3.31	2.70	3.42	2.87	2.86	4.03	3.31	2.84	3.53	2.95	2.82	3.15	2.64	3.26	3.36	3.34	2.94	3.41	3.12
9. Татварын үйл ажиллагаа	Татварын тодорхойлолт авах хүндрэл, бэрхшээл	2.52	3.04	2.57	2.32	2.57	2.41	2.35	4.04	3.40	2.83	3.46	2.91	2.65	3.56	2.03	3.39	3.36	2.80	2.53	3.59	2.78
	Татварын ажилтнуудын харилцааны соёл, ёс зүй	2.68	3.37	2.61	2.13	2.69	2.67	2.65	3.96	3.65	3.78	3.76	3.16	3.41	3.65	2.31	3.37	3.38	3.86	3.11	3.79	3.07

№	ҮЗҮҮЛЭЛТ																					
		ДЗ 1-р баг	ДЗ 2-р баг	ДЗ 3-р баг	ДЗ 4-р баг	ДЗ 5-р баг	ДЗ 6-р баг	ДЗ 7-р баг	ДЗ 8-р баг	Баян-Овоо	Булган	Гурвантэс	Мандал-Овоо	Манлай	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогт-Овоо	Цогтцэцэй	Номгон	Аймаг
10. Уул уурхайн үйл ажиллагаа	Уур уурхайн нөхөн сэргээлтийн ажил	2.74	3.00	2.56	2.38	3.09	2.42	2.46	3.82	3.25	1.83	3.18	2.88	2.35	2.84	2.45	2.91	2.62	2.64	2.26	3.29	2.69
	Уур уурхайн нээлттэй ажлын байрны сонгон шалгаруулалтын шударга байдал	2.90	3.00	2.64	2.47	2.82	2.55	2.58	3.90	3.38	2.24	3.42	2.74	2.31	3.24	2.33	2.91	2.38	2.38	2.45	3.19	2.75
	Уул уурхайн компаниуд орон нутагт хөрөнгө оруулалт, нийгмийн хариуцлага	2.99	3.40	3.15	2.45	3.88	2.85	3.17	3.88	4.29	2.28	3.59	2.98	2.72	3.25	2.78	3.22	3.33	2.88	2.58	3.13	3.07
11. Батлан хамгаалах	Оюутан цэрэг хөтөлбөр	2.77	3.36	2.06	2.53	4.08	2.43	2.87	3.97	3.04	3.12	3.83	1.81	2.62	2.53	1.88	3.72	3.00	3.00	2.71	3.18	2.83
	Цэрэг татлагын үйл ажиллагаа	2.70	3.54	2.37	2.57	3.58	2.50	2.84	4.03	3.19	3.86	3.90	2.05	2.60	3.73	1.98	2.63	3.40	3.12	2.88	3.51	2.94
	Аймгийн цэргийн штабын үйл ажиллагаа	2.68	3.50	2.28	3.03	3.63	2.46	2.83	4.11	3.21	3.40	3.83	1.91	1.90	2.60	1.56	2.70	3.17	3.10	2.60	3.32	2.77
12. Засаглал	Аймагас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа	3.99	3.96	3.36	3.49	4.71	3.79	4.03	4.44	3.90	4.36	3.60	4.05	3.76	3.91	2.15	4.30	4.00	4.66	2.85	3.79	3.62
	Аймагас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмж	3.81	4.11	3.26	3.79	4.65	3.70	3.78	4.40	3.81	4.40	3.48	4.23	3.68	4.00	2.15	4.26	4.02	4.60	2.70	3.88	3.58
	Сумаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа	4.03	4.01	3.61	3.68	4.49	3.64	3.64	4.14	4.13	4.38	3.74	3.63	3.81	4.40	2.76	4.30	4.52	4.76	2.87	4.09	3.73
	Сумаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмж	3.94	3.99	3.53	3.43	4.45	3.72	3.78	4.10	4.15	4.31	3.73	3.44	3.63	4.51	2.68	4.35	4.33	4.84	2.78	3.97	3.67
	Аймаг, сумын удирдлагын бодлого шийдвэрийн ил тод, нээлттэй байдал	3.93	3.44	3.26	3.53	4.35	3.55	3.30	4.15	3.92	4.10	3.45	3.98	3.43	4.02	2.33	4.17	4.21	4.20	2.46	3.74	3.45
	Хот төлөвлөлтийг оновчтой шийдсэн эсэх	3.96	4.07	3.74	3.87	4.88	3.67	3.52	4.26	3.98	3.74	3.67	3.93	3.66	4.27	2.83	4.26	4.02	4.28	2.51	3.79	3.65
	Хотжилтын өнгө төрх	4.08	4.44	4.07	3.64	4.97	4.15	4.30	4.29	4.17	3.84	4.02	3.88	3.81	4.78	3.23	4.22	4.48	4.58	2.71	3.88	3.91
	Аймаг, сумын төсвийн зарцуулалт	3.93	3.96	3.22	3.14	4.12	3.35	3.51	4.04	3.98	3.29	3.26	3.12	3.53	4.00	1.89	4.20	3.67	3.76	2.55	3.66	3.30
	Төсвийн зарцуулалтад тавих иргэдийн хяналт	3.57	3.37	2.99	2.70	3.28	2.81	2.36	4.07	3.65	3.03	3.15	2.91	3.09	3.64	1.78	3.98	3.60	3.08	2.38	3.46	2.97
	ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэд оролцож хяналт тавих боломж	3.38	3.49	2.63	2.55	3.60	2.99	2.57	4.10	3.73	3.10	3.09	2.74	3.12	4.09	1.78	3.83	3.69	3.94	2.45	3.60	3.01

Хавсралт 2. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үйлчилгээний чанар, хүртээмж болон сумаар

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДЗ 1-р баг	ДЗ 2-р баг	ДЗ 3-р баг	ДЗ 4-р баг	ДЗ 5-р баг	ДЗ 6-р баг	ДЗ 7-р баг	ДЗ 8-р баг	Баян-Овоо	Булган	Гурвантас	Мандал-Овоо	Манлай	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хурмэн	Цогт-Овоо	Цогтцэцэй	Номгон	Аймаг
1. Үйлчилгээний чанар	Төрийн ажилтнуудын асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг хичээдэг байдал	3.92	4.01	3.76	3.98	4.55	3.90	4.00	4.68	4.04	4.36	4.43	4.28	4.09	4.45	3.89	4.41	4.40	4.56	3.55	4.28	4.08
	Ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэг	4.07	4.17	4.02	4.13	4.68	4.11	4.14	4.74	4.15	4.53	4.54	4.16	4.21	4.65	4.16	4.46	4.60	4.70	3.69	4.43	4.24
	Ажилтнуудын ажлын бүтээмж	4.02	4.20	3.95	4.13	4.65	4.05	4.14	4.75	4.17	4.48	4.51	4.28	4.19	4.64	4.10	4.26	4.62	4.56	3.51	4.43	4.19
	Хариу эргэн мэдээлдэг байдал	3.90	3.99	3.88	4.00	4.42	3.59	3.96	4.71	4.04	4.22	4.37	4.19	4.12	4.45	3.92	4.17	4.40	4.40	3.40	4.28	4.02
	Иргэн санал гомдлоо илэрхийлэх боломж, нээлттэй байдал	3.93	3.90	3.82	4.09	4.35	3.80	3.91	4.66	4.02	4.34	4.50	4.19	4.18	4.64	3.97	4.46	4.50	4.56	3.35	4.28	4.07
2. Үйлчилгээний хүртээмж	Үйлчилгээний ачааллын хэвийн байдал	3.98	4.06	3.88	4.25	4.48	3.81	4.09	4.73	4.29	4.41	4.48	4.51	4.22	4.53	4.00	4.46	4.55	4.64	3.54	4.22	4.14
	Үйлчилгээг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх зэрэг энгийн ойлгомжтой байдал	4.07	4.13	4.00	4.22	4.71	4.01	4.10	4.77	4.08	4.48	4.58	4.49	4.28	4.65	4.07	4.57	4.50	4.62	3.69	4.15	4.22
	Холбогдох үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод байдлын самбар гэх мэт	4.06	4.16	4.00	4.12	4.65	3.87	4.20	4.79	4.15	4.36	4.61	4.51	4.29	4.69	4.02	4.52	4.40	4.58	3.64	4.24	4.20
	Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөө авах боломжтой байдал	4.05	4.14	3.98	4.23	4.68	3.93	4.17	4.78	4.15	4.33	4.56	4.44	4.32	4.75	4.07	4.46	4.55	4.60	3.67	4.28	4.21
3. Албан хаагчийн харилцааны ёс зүй	Ажилтнууд таньд туслахад бэлэн байдаг (хандлага)	4.10	4.06	3.93	4.17	4.60	3.94	4.23	4.75	4.21	4.69	4.59	4.33	4.25	4.62	4.13	4.50	4.67	4.84	3.85	4.37	4.25
	Ажилтнуудын эерэг таатай харилцаа	4.06	4.09	4.07	4.15	4.60	4.12	4.30	4.77	4.29	4.52	4.63	4.30	4.31	4.58	4.19	4.57	4.67	4.72	3.90	4.37	4.29
	Ажилтнууд бүх иргэдтэй ижил тэгш харилцах байдал	4.03	3.96	3.88	3.94	4.23	3.80	4.07	4.78	4.17	4.52	4.48	4.30	4.26	4.56	4.08	4.48	4.55	4.46	3.65	4.35	4.14
	Ажилдаа хариуцлагатай ханддаг	4.06	4.11	3.96	4.15	4.58	3.93	4.14	4.79	4.27	4.47	4.47	4.21	4.31	4.69	4.12	4.54	4.60	4.64	3.65	4.31	4.21
	Ажилтнуудын цаг баримтлах, цаг ашиглах байдал	3.97	4.00	3.82	3.91	4.45	3.75	4.01	-	4.04	4.07	4.21	3.93	4.00	4.51	3.88	-	4.50	4.36	3.37	4.18	3.96
	Шударга байдал (гар харах гэх мэт)	4.04	3.94	4.06	3.83	4.32	3.65	3.96	-	3.63	3.12	2.17	4.30	3.97	4.60	3.49	-	4.48	4.64	3.66	2.71	3.69
4. Төрийн байгууллагын орчин	Байгууллагын гадна болон доторх тэмдэг, тэмдэглэгээ харагдахуйц ойлгомжтой байдал	4.27	4.49	4.06	4.45	4.91	4.38	4.49	4.86	4.31	4.69	4.75	4.56	4.38	4.85	4.17	4.54	4.79	4.76	4.18	4.44	4.44
	Үйлчилгээний төвийн доторх үзгэн бал, маягт, цаас гэх мэт туслах зүйлсийн хүрэлцээ	4.08	4.33	4.08	4.20	4.62	4.09	4.26	4.86	4.35	4.59	4.67	4.65	4.34	4.75	4.01	4.37	4.55	4.46	3.82	4.28	4.28
	Хүлээлгийн танхим дахь ширээ сандалын хүртээмж	4.14	4.17	3.92	4.02	4.48	4.14	4.29	4.77	4.44	4.47	4.65	4.67	4.37	4.76	3.99	4.39	4.57	4.48	3.74	4.28	4.25
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал	3.79	3.93	3.62	3.86	4.49	3.64	3.87	4.78	4.17	4.03	4.43	4.47	4.18	4.44	3.00	4.15	4.36	4.02	2.93	4.07	3.83

Хавсралт 3
Иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах
санал асуулгын хуудас

Зорилго:

Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, түүнд дүн шинжилгээ хийн цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

Тайлбар: Судалгаанд оролцогчдын хувийн мэдээллийг чандлан нууцлах тул үнэн зөв, шударгаар хариулна уу.

НЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Судалгаанд хамрагдаж буй аймаг, сум

1. Аймаг/Нийслэл 2. Сум/дүүрэг 3. Утасны дугаар

2. Таны хүйс 1. Эрэгтэй 2. Эмэгтэй

3. Таны нас (18-аас дээш насны хүмүүс судалгаанд хамрагдана)

4. Таны боловсрол

1. Боловсролгүй
2. Бага /3/4 анги/
3. Суурь /8/9 анги/
4. Бүрэн дунд /10/11/12 анги/
5. Техник болон мэргэжлийн дунд (МСҮТ)
6. Тусгай мэргэжлийн дунд (коллеж)
7. Дээд

5. Таны ажил эрхэлдэг салбар

1. Ажилгүй
2. Төрийн байгууллага
3. Төрийн бус байгууллага
4. Олон улсын байгууллага
5. Хувийн хэвшил, компани
6. Хувиараа бизнес эрхэлдэг
7. Өндөр насны тэтгэвэрт
8. Бусад.....

6. Танай өрхийн сарын орлого хэд вэ? (Төгрөгөөр) (дараах орлогуудыг бүгдийг хамруулна: цалин, халамж, тэтгэвэр, тэтгэмж, бизнесийн орлого, түрээсийн орлого, дотоод, гадаадад ажилладаг өрхийн гишүүний мөнгөн гуйвуулга болон хадгаламжийн хүүгийн хувь хэмжээ гм)

1. 250 000 – аас доош
2. 250 001 - 500 000
3. 500 001 - 750 000
4. 750 001 - 1 000 000
5. 1 000 001 - 1 500 000
6. 1 500 001 - 2 000 000
7. 2 000 001- аас дээш

7. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд танай өрхийн амьжиргаа хэрхэн өөрчлөгдсөн бэ?

1. Мэдэгдэхүйц дээшилсэн
2. Бага зэрэг дээшилсэн
3. Хэвэндээ
4. Бага зэрэг доошилсон

5. Бүр дордсон

ХОЁР: САЛБАР ЧИГ ҮҮРГИЙН ҮНЭЛГЭЭ

№	Үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Мэдэхгүй
1. Эрүүл мэнд							
1	Та сүүлийн нэг жилийн хугацаанд аймаг, сумын эмнэлгээр үйлчлүүлсэн үү?	Тийм -> Асуулт 2			Үгүй -> 2.Боловсрол, соёл спорт		
2	“Эрт илрүүлэг” үзлэг, оношилгооны хүртээмж хэр байна вэ?						
3	Таны үйлчлүүлсэн эмнэлгийн ачаалал хэр их байсан бэ?	1	2	3	4	5	0
4	Таны үйлчлүүлсэн эмнэлгийн үйлчилгээний чанар ямар байсан бэ?	1	2	3	4	5	0
5	Таны үйлчлүүлсэн эмнэлгийн дотоод орчин хэр тохилог, тухтай, цэвэрхэн байсан бэ?	1	2	3	4	5	0
6	Түргэн тусламж 103-ийн үйл ажиллагаа хэр санагддаг вэ?	1	2	3	4	5	0
7	Эмч эмнэлгийн ажилчдын харилцаа, ёс зүйг ямар гэж дүгнэдэг вэ?	1	2	3	4	5	0
2. Боловсрол, соёл, спорт							
8	Сүүлийн нэг жилийн хугацаанд танай хүүхэд төрийн өмчийн ЕБС, цэцэрлэгт хамрагдсан уу?	Тийм -> Асуулт 9			Үгүй -> Асуулт 13		
9	ЕБС-ийн сургалтын орчин, нөхцөл, сургалтын материалын хангамж хэр байна вэ? (Төрийн өмчийн сургууль)	1	2	3	4	5	0
10	ЕБС-ийн сургалтын чанарт үнэлгээ өгнө үү?	1	2	3	4	5	0
11	ЕБС-ийн багш нарын ур чадварт үнэлгээ өгнө үү?	1	2	3	4	5	0
12	Цэцэрлэгийн багш нарын чадварт үнэлгээ өгнө үү?	1	2	3	4	5	0
13	Таны амьдарч буй газарт чөлөөт цагаа өнгөрөөх газар хэр хангалттай байна вэ?	1	2	3	4	5	0
14	Урлаг соёлын үйлчилгээ хэр зохион байгуулагддаг вэ? үнэлгээ өгнө үү.	1	2	3	4	5	0
15	Та болон танай гэр бүлийн гишүүд спортоор хичээллэдэг эсэхэд үнэлгээ өгнө үү?	1	2	3	4	5	0
16	Нийтийн биеийн тамирын байгууламжийн хүртээмжийг үнэлнэ үү? (Зал, танхим, талбай г.м)	1	2	3	4	5	0
3. Нийтийн тээвэр							
17	Та нийтийн тээврээр тогтмол үйлчлүүлдэг үү?	Тийм -> Асуулт 18			Үгүй -> Асуулт 21		
18	Нийтийн тээвэр хэр цэвэр тухтай байна вэ?	3	2	3	4	5	0
19	Нийтийн тээврийн үйлчилгээний маршрут, цагийн хуваарь хэр ойлгомжтой байдаг вэ?	1	2	3	4	5	0
20	Нийтийн тээврийн үйлчилгээ маршрут, цагийн хуваариа хэр мөрддөг вэ?	1	2	3	4	5	0
21	Авто замын засвар, шинэчлэлтийн ажил хэр хийгддэг вэ?	1	2	3	4	5	0
22	Цасны цэвэрлэгээ, замын хальтиргаа арилгах үйлчилгээг үнэлнэ үү?	1	2	3	4	5	0
4. Дэд бүтэц							
23	Таны амьдардаг газар цахилгаан, ус, дулаанд холбогдсон уу?	Тийм -> Асуулт 24			Үгүй -> Асуулт 27		
24	Танай гэрт цахилгааны доголдол, тасалдал хэр их гардаг вэ?	1	2	3	4	5	0
25	Танай гэрт халуун усны доголдол, тасалдал, хэр их гардаг вэ?	1	2	3	4	5	0

	(зуны цагийн урсгал болон их засварын ажлыг тооцохгүй)						
26	Шөнийн тарифын хөнгөлөлтийг та хэрхэн үнэлэх вэ?	1	2	3	4	5	0
27	Бохир ус зайлуулах үйлчилгээг та хэрхэн үнэлэх вэ?	1	2	3	4	5	0
28	Хог зайлуулах үйлчилгээний чанар хэр байна вэ?	1	2	3	4	5	0
5. Аюулгүй байдал, шударга ёс							
29	Таны бодлоор хууль, дүрэм, журам хүн бүрт хэр тэгш үйлчилж байна вэ?	1	2	3	4	5	0
30	Таны амьдарч буй орчин хэр аюулгүй байна вэ?	1	2	3	4	5	0
31	Танай гэрийн ойролцоо хүүхэд гадаа тоглоход хэр аюулгүй байна вэ?	1	2	3	4	5	0
32	Цагдаагийн 102-ийн үйлчилгээний түргэн шуурхай байдлыг үнэлнэ үү?	1	2	3	4	5	0
33	Цагдаагийн албан хаагчдын харилцааны соёл, ёс зүйг юу гэж дүгнэх вэ?	1	2	3	4	5	0
6. Хүнс, хөдөө аж ахуй							
34	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгож буй зээлийн үйлчилгээний талаар үнэлгээ өгнө үү?	1	2	3	4	5	0
35	Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн дүгнэх вэ?	1	2	3	4	5	0
36	Мал, махны худалдааны хүртээмж, үнэ ямар байна вэ?	1	2	3	4	5	0
37	Дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж, хүртээмжийг юу гэж дүгнэх вэ?	1	2	3	4	5	0
38	Хүнсний аюулгүй байдал, хүртээмжийн талаар ямар бодолтой байна вэ?	1	2	3	4	5	0
7. Эрүүл орчин							
39	Танай гэрийн ойролцоо агаарын бохирдол (өвлийн улиралд)хэр их байна вэ?	1	2	3	4	5	0
40	Танай гэрийн ойролцоо хөрсний бохирдол хэр их байна вэ?	1	2	3	4	5	0
41	Танай гэрийн ойролцоо ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн хэр хангалттай байна вэ?	1	2	3	4	5	0
42	Цаг агаарын мэдээг цаг алдалгүй авч чаддаг уу? хэрхэн үнэлэх вэ?	1	2	3	4	5	0
8. Ажил эрхлэлт, нийгмийн даатгал							
43	Та шинээр гарч буй ажлын байрны талаарх мэдээллийг хэр тогтмол гардаг гэж үнэлэх вэ?	1	2	3	4	5	0
44	Таны эргэн тойронд шинээр ажлын байрууд нэмэгдэж байна уу?	1	2	3	4	5	0
45	Та нийгмийн даатгалд тогтмол хамрагдсанаар гарах ашиг, давуу талыг хэр сайн мэдэх вэ?	1	2	3	4	5	0
46	Халамж, тэтгэмж, зорилтот бүлэгтээ хүрч чадаж байна уу? Та юу гэж үнэлэх вэ?	1	2	3	4	5	0
9. Татварын үйл ажиллагаа							
47	НӨАТ-ын буцаан олголтын үйл ажиллагааг юу гэж боддог вэ?	1	2	3	4	5	0
48	Татварын тодорхойлолт авч байсан уу? Үйлчилгээ хэр санагдсан бэ?	1	2	3	4	5	0
49	Татварын ажилтнуудын харилцааны соёл, ёс зүйг хэрхэн үнэлэх вэ?	1	2	3	4	5	0
10. Уул уурхайн үйл ажиллагаа							
50	Уур уурхайн нөхөн сэргээлтийн ажил хэр хийгдэж байна вэ?	1	2	3	4	5	0
51	Уур уурхайн нээлттэй ажлын байрны сонгон шалгаруулалтын шударга байдлыг үнэлнэ үү?	1	2	3	4	5	0
52	Уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийж байна уу?	1	2	3	4	5	0
11. Батлан хамгаалах							
53	Оюутан цэрэг хөтөлбөрийн талаарх таны үнэлгээ	1	2	3	4	5	0

54	Цэрэг татлагын үйл ажиллагааг үнэлнэ үү?	1	2	3	4	5	0
55	Аймгийн цэргийн штабын үйл ажиллагааг үнэлнэ үү?	1	2	3	4	5	0
12. Засаглал							
56	Та аймгаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанд хэр сэтгэл хангалуун байна вэ?	1	2	3	4	5	0
57	Та аймгаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр хангалттай авч байна вэ?	1	2	3	4	5	0
58	Таны амьдарч буй суманд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанд хэр сэтгэл хангалуун байна вэ?	1	2	3	4	5	0
59	Таны амьдарч буй суманд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэр хангалттай авч байна вэ?	1	2	3	4	5	0
60	Нийслэл, аймаг, сум, дүүргийн удирдлагын бодлого шийдвэрүүд хэр ил тод, нээлттэй байна вэ?	1	2	3	4	5	0
61	Таны амьдарч буй газрын хот төлөвлөлтийг хэр оновчтой шийдсэн бэ?	1	2	3	4	5	0
62	Таны амьдарч буй газрын хотжилтын өнгө төрх хэр байна вэ?	1	2	3	4	5	0
63	Таны амьдарч буй аймаг, сумын төсвийн зарцуулалт хэр оновчтой байна вэ? Хэрэгтэй зүйлдээ зарцуулагддаг уу?	1	2	3	4	5	0
64	Төсвийн зарцуулалтад иргэд хэр хяналт тавьдаг вэ?	1	2	3	4	5	0
65	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд иргэд оролцож хяналт тавьж чадаж байна уу? Нээлттэй ил тод байдал хэр вэ?	1	2	3	4	5	0

ГУРАВ: ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖ

(Энэ хэсэгт та хамгийн сүүлд үйлчлүүлсэн байгууллагын үйлчилгээний талаар үнэлгээ өгнө)

1. Та хамгийн сүүлд төрийн байгууллагаас ямар хэлбэрээр үйлчилгээ авсан бэ?

1. Шууд үйлчилгээ авах
2. Лавлагаа, тодорхойлолт авах
3. Мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмж авах
4. Өргөдөл гомдол, санал хүсэлт өгөх
5. Зуучлах (*авах гэж буй үйлчилгээтэй холбоотой материалуудаа бүрдүүлээд өгөх, төрийн ажилтан нь түүнийг хэлтэсдээ хүргэх, буцаан олгох гэх мэт*)
6. Бусад

2. Та хамгийн сүүлд авсан төрийн үйлчилгээний төрлийг нэрлэнэ үү? (авсан үйлчилгээг нарийн тодорхой бичнэ. Жишээлбэл: тэтгэврийн хэмжээ тогтоолгох гэж нийгмийн даатгалын үйлчилгээ авсан гэх мэт)

.....

.....

3. Та өөрийн хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадсан уу?

1. Бүрэн авч чадаагүй бөгөөд надад үйлчлэхээс татгалзсан
2. Бүрэн авч чадаагүй гарсан
3. Бүрэн авч чадаагүй ч ямар нэг хариу, хэрэгтэй зөвлөгөө авсан
4. Хагас дутуу авсан
5. Үйлчилгээгээ бүрэн авсан

4. Та нэг төрлийн үйлчилгээ авахын тулд хэдэн удаа төрийн байгууллагаар ирэх шаардлагатай болсон бэ?

1. 1 удаа
2. 2 удаа
3. 3-4 удаа

4. 5-аас дээш удаа

5. Та нэг удаа үйлчилгээ авахад хэдэн байгууллагаар дамжин орсон бэ?

1. 1 байгууллага
2. 2 байгууллага
3. 3 байгууллага
4. 4 болон түүнээс дээш байгууллага

6. Та үзүүлэлт бүрээр төрийн үйлчилгээний чанарыг үнэлнэ үү?

№	Үзүүлэлт	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
1	Төрийн байгууллагын ажилтнууд ямарваа нэг асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг хичээдэг байдал	1	2	3	4	5
2	Ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэг	1	2	3	4	5
3	Ажилтнуудын ажлын бүтээмж хэр вэ?	1	2	3	4	5
4	Хариу эргэн мэдээлдэг байдал	1	2	3	4	5
5	Иргэн санал гомдлоо илэрхийлэх боломж нээлттэй байдал	1	2	3	4	5

7. Та төрийн үйлчилгээний хүртээмжийг үнэлнэ үү?

№	Үзүүлэлт	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
1	Үйлчилгээний ачааллын хэвийн байдал	1	2	3	4	5
2	Үйлчилгээг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх зэрэг энгийн ойлгомжтой байдал	1	2	3	4	5
3	Холбогдох үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод байдлын самбар гэх мэт	1	2	3	4	5
4	Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөө авах боломжтой байдал	1	2	3	4	5

8. Та тухайн төрийн үйлчилгээний албан хаагчийн ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙГ үнэлнэ үү?

№	Үзүүлэлт	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
1	Ажилтнууд таньд туслахад бэлэн байсан уу? (хандлага)	1	2	3	4	5
2	Ажилтнуудын эерэг таатай харилцаа	1	2	3	4	5
3	Ажилтнууд бүх иргэдтэй ижил тэгш харилцдаг уу?	1	2	3	4	5
4	Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал	1	2	3	4	5
5	Ажилтнуудын цаг баримтлах, цаг ашиглах байдал хэр вэ?	1	2	3	4	5
6	Тухайн ажилтан таньд үйлчлэхдээ гар хардаг уу? (бэлэг дурсгал, мөнгө гэх мэт)	1	2	3	4	5

9. Та өөрийн үйлчлүүлсэн төрийн байгууллагын орчныг үнэлнэ үү?

№	Үзүүлэлт	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
1	Байгууллагын гадна болон доторх тэмдэг,	1	2	3	4	5

	тэмдэглэгээ харагдахуйц ойлгомжтой байдал					
2	Үйлчилгээний төвийн доторх үзгэн бал, маягт, цаас гэх мэт туслах зүйлсийн хэрэгцээ хангалттай байсан уу?	1	2	3	4	5
3	Хүлээлгийн танхимын ширээ сандалын хүртээмжтэй байдал хэр вэ?	1	2	3	4	5
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал (шат, бариул, хаалга гэх мэт)	1	2	3	4	5

10. Таны үйлчлүүлсэн төрийн байгууллагын албан хаагчийн нэр, албан тушаал, хаягжилт гэх мэт мэдээлэл нээлттэй байсан уу?

1. Тийм, шаардлагатай бүх мэдээлэл бүрэн байсан
2. Зарим мэдээлэл нь байсан
3. Холбогдох мэдээлэл огт байгаагүй

11. Та төрийн байгууллагын үйлчилгээний мэдээллийг хаанаас авбал танд хялбар байдаг вэ?

1. Телевиз
2. Интернет, тухайн байгууллагын вэб сайт
3. Мэдээллийн самбар, зурагт хуудас
4. Гарын авлага, тараах материал
5. Хэвлэл, сонин
6. Төрийн байгууллагын мэргэжилтнүүд
7. Нэг цэгийн үйлчилгээний ажилчдаас
8. Бусад.....

12. Таны амьдарч буй газарт тулгамдаж байгаа асуудал болон нэн тэргүүнд шийдвэрлээсэй гэж хүссэн асуудлаа бичнэ үү. (3 хүртэлх асуудлыг нэрлэнэ үү)

1.
2.
3.
4.

13. 2023 онд аймаг, орон нутагт хийгдсэн хамгийн үр дүнтэй ажлаас 1-3 ыг нэрлэнэ үү.

- 1.....
- 2.....
- 3.....

**АСУУЛГАД ИДЭВХ САНААЧИЛГАТАЙ ХАРИУЛСАН
ЭРХЭМ ТАНД БАЯРЛАЛАА**